

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-18
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	19-55
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	20-21
2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/	21-55

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 29-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, Ж.Баясгалан, Б.Бейсен, Т.Мөнхсайхан,
Б.Түвшин, Д.Энхтуяа, М.Энхцэцэг.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Ганзориг “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Ганзориг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 15 цаг 52 минутаас 16 цаг 40 минутад завсарлав.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөх Г.Саран, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, шинжээч Б.Баянжаргал, Э.Цэрэнбат, ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, А.Уртнасан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч Э.Тамир, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч Ч.Нанжидсамбуу, мөн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга Э.Энхжаргал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны дарга Д.Далхжав, Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, П.Наранбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпхар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нар болон Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийн “хоёр хүртэлх гэрээнээс сонгон” гэснийг “нэг гэрээнээс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22” гэснийг “15-24” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “25” гэснийг “26” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл энэ чөлөөлөлтөд хамаарна. Энэ ажил олгогчийн шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.”

Тайлбар:Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс” гэсний дараа “доошгүй орлогоос” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их, дээд сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч, мөн тухайн насны бүтэн бус цагийн ажил эрхэлж буй ажилтан өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Эхний 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа гарааны бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 21 дүгээр зүйлийн 21.30 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.29-д заасан ажил олгогчид төрийн

болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, гадаад улсын олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага хамаарахгүй” гэсэн заалтаас “төрийн бус байгууллага” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 19.5 дахь заалтын “хөлсний доод” гэсний араас “хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 16
Бүгд: 21
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үг хэлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 15
Бүгд: 21
28.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын “дэмжээгүй” санал “дэмжсэн” гарсан тул санал хураалтыг дэмжээгүйгээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 1 болон 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба

хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “биечлэн” гэсний дараа “, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн бол асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “0.3, 1.0, 1.5” гэснийг “0.3, 1.2, 2.2” гэж, “10.4, 11.1, 11.6” гэснийг “10.4, 11.3, 12.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 19
Бүгд: 21
9.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 19
Бүгд: 21
9.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4.10 дахь заалт, мөн зүйлийн 7.10 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсгийн “шимтгэл төлөлтийн” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “тухайн гэрээ бүрт” гэснийг, мөн зүйлийн 6 дахь

заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт болон 7, 10 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд 2 дугаар зүйл шинээр нэмэх:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6

Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 3 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журам, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч Э.Тамир нар хариулж, тайлбар хийв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.8.“суурь тэтгэвэр” гэж авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тус тус авч байгаа ахмад настанд улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлж, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 13

Бүгд: 21

38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 17

Бүгд: 21

19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 9.1.3-т “нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авч байх.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 17

Бүгд: 21

19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 16

Бүгд: 21

23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэгт дурдагдсан “2027” гэснийг “2027, 2028” гэж, “2028” гэснийг “2029” гэж, “2029” гэснийг “2030” гэж, “2030” гэснийг “2031” гэж, “2031” гэснийг “2032” гэж “2032” гэснийг “2033” гэж тус тус харгалзуулан өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Суурь тэтгэврийг доор дурдсан насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгоно:

3.4.1.өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч;

3.4.2.энэ хуулийн 5.1.2-5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй 60 насанд хүрсэн, эмэгтэй 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч, мөн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсан тэтгэвэр авагч.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 15
Бүгд: 21
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасаж, дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн “баталгаат тэтгэвэр” гэснийг “суурь тэтгэвэр” болгон өөрчилсөнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдэд тусгасан баталгаат тэтгэвэртэй холбоотой зүйл, хэсэг, заалтуудыг уялдуулан өөрчлөх, тус тус найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Байнгын хорооны дарга П.Ганзориг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (С_т)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийг” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3, 4 дүгээр зүйлийг хасаж, дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр олгогдсон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (C_T)-ийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 6
Бүгд: 21
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 14.1.6 дахь заалтын “засах” гэсний дараа “гэрээр асрах, сувилах болон хувилбарт тусламж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй тэтгэвэр авагчид 60 насанд, эмэгтэй тэтгэвэр авагчид 55 насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1} дэх хэсэгт заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 11.1 дэх хэсгийг “ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараа өдрөөс эхлэн ажлын 55 хоногоор тооцон олгоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар үг хэлж, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч Э.Тамир тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 15
Бүгд: 21
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

П.Ганзориг: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн

эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 42 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн ирсэн байна. Тэгээд гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурал /УИХ/-ын гишүүн Аюушийн Ариунзаяа ирсэн байна, УИХ-ын гишүүн Цэндийн Баатархүү ирсэн байна, УИХ-ын гишүүн Отгоншарын Батнайрамдал ирсэн байна, УИХ-ын гишүүн Хөххүүгийн Болормаа ирсэн байна, УИХ-ын гишүүн Жанчивын Галбадрах ирсэн байна, УИХ-ын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн байна, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн байна, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Лутаагийн Энхнасан гишүүн ирсэн байна. Ингээд өнөөдрийн хуралдаанд оролцсон 16 гишүүний нэрсийг танилцууллаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя 1 дүгээрт, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Засгийн газар болон УИХ-ын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн төслүүдийг нэгтгэсэн төсөл анхны хэлэлцүүлэг явуулна. 2-т Байнгын хорооны тогтоолын төсөл буюу ажлын хэсэг байгуулна. Энэ ажлын хэсэг УИХ-ын гишүүн Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсэг байгуулах ийм тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүд байна уу? Аюушийн Ариунзаяа гишүүн байна.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах горимын санал гаргаж байна. Нийгмийн даатгалын хуулиудыг хэлэлцэх ажлын хэсгийн хуралдаан дуусаагүй байгаа учраас 2 дахь асуудлаар хэлэлцэх ажлын хэсэг байгуулах тогтоолыг 1 дүгээр асуудлаар хэлэлцэж өгөх ийм санал гаргаж байна. Хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

П.Ганзориг: Засгийн газраас яаралтай горимоор өргөн барьсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн ингээд ажлын хэсэг Их Хурлын даргаас Хүрэлбаатарын

Булгантуяа гишүүнээр ахлуулаад гарсан. Ингээд уг нь ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ ажлын хэсэг маань цагтаа хурлаа хийж чадахгүй хойшлоод, тэгээд энэ Байнгын хорооны хурал, манай Байнгын хорооны хурал уг нь 14:30-д эхлэх байсан. Тэгээд 14:30-аас хойш хүлээлээ. Тэгээд энэ хэлэлцэх асуудал нь дуусаагүй байгаа тул Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналаар явах нь зүйтэй гэж үзэж байна. Тэгээд Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү.

Аюушийн Ариунзаяа гишүүний гаргасан хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөх горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 87.5 хувиар дэмжигдлээ. Ингээд эхний асуудалдаа орёе.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

УИХ-ын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийг, төслийг бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг танилцуулъя. Тогтоолын төсөл бэлэн болсон уу? Монгол УИХ-ын Байнгын хорооны тогтоолыг танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.УИХ-ын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагчаар Т.Мөнхсайхан гишүүн, Монгол УИХ-ын гишүүн Мөнхсайхан. Ажлын хэсгийн гишүүдээр Лутаагийн Энхнасан гишүүн, О.Саранчулуун гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, Г.Хосбаяр гишүүн, Б.Бейсен гишүүн, П.Наранбаяр гишүүн нарын бүрэлдэхүүнтэй байна. Ингээд 2-т, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Т.Мөнхсайханд зөвшөөрсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. 7 гишүүн байна. Ингээд тогтоолын төслөө батлах санал хураалтад бэлдэх нь үү гишүүд. Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 17 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 82.4 хувиар дэмжигдэж тогтоолын төсөл батлагдлаа. Энэ том чухал хуулийн ажлын хэсгийг ахалж болон ажлын хэсэгт орж ажиллаж байгаа нийт Их Хурлынхаа гишүүдэд амжилт хүсье. Ингээд эхний асуудал дууслаа. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.51 цаг

2 дахь асуудал ажлын хэсэг санал хураалтуудаа дуусгаж нэгтгээд, энэ Байнгын хороон дээр орж ирж санал хураалгах ёстой. Тэгэхээр ажлын хэсэг хуралдаж байгаа тул хүлээе дээ хэдүүлээ. Тийм ямар ч байсан 30 минут хүлээе дээ, 30 минут хүлээж байгаад асуудал нь дуусаад орж ирвэл хэдүүлээ үргэлжлүүлээд Байнгын хорооныхоо хурлыг үргэлжлүүлээд явуулъя. Ажлын хэсгийн санал хураалтууд ерөнхийдөө дуусаж байгаа юм байна. Тэгэхээр 30 минут биш 15 минутын дараа 2 дахь асуудлаа үргэлжлүүлээд явуулъя.

Хуралдаан 15 цаг 52 минутаас 16 цаг 40 минутад завсарлав.

Танхимд орж ирэхийг хүсье. Өнөөдөр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор 2 асуудал хэлэлцэх ёстой, 2 дахь асуудлаа хэлэлцэх гээд хүлээж байна. Хурлаар хэлэлцэх 2 дахь асуудалдаа оръё.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Засгийн газар болон А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаа юу, нэрс? Танилцуулга хийж байх хооронд нэрсээ өгөөрэй. Тэгээд Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Булгантуяа гишүүний танилцуулгыг хүсье.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, оруулалт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, УИХ-ын Б.Түвшин нарын 41 гишүүн 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, УИХ-ын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлсэн.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.26-нд 1 асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасныг үндэслэн Засгийн газар болон дээр дурдсан гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын даргын 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн

279 дүгээр захирамжаар УИХ-ын гишүүн Х.Булгантуяагаар ахлуулж, УИХ-ын гишүүн Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпхар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 2026 оны 6 дугаар сарын 26, 28-ны өдрүүдэд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монгол Үйлдвэрчний эвлэлийн холбоо /МҮЭХ/, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-тай өргөн хүрээний уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын дүнд үндэслэн ажлын хэсэг нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан 36 зарчмын зөрүүтэй санал боловсруулж, 2026 оны 6 сарын 29-ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаараа хэлэлцэж, дэмжсэн болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

П.Ганзориг: Танилцуулга хийсэн ажлын хэсгийн ахлагчид баярлалаа. Байнгын хорооны хуралд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Т.Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Аубакир сайд байгаа юм уу, энэ дээр байгаа гээд тэмдэглэчихсэн байна. Л.Мөнхзул Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газар /НДЕГ/-ын дарга, Ц.Ганцэцэг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Э.Энхжаргал Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо /МАОЭНХ/-ны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга, Ч.Өнөржаргал Санхүү, эдийн засгийн их сургууль /СЭЗИС/-ийн багш, судлаач, Э.Цэрэнбат Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Б.Баяржаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Б.Мөнхбаяр тус яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч, З.Пунцагцэрэн НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, А.Уртнасан НДЕГ-ын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Ц.Нанжидсамбуу Ажил олгогч эздийн холбооны ерөнхийлөгч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэнэ гэж заасан. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагч болон оролцогчдоос асуулт асууж болно. Ингээд төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах болон асуулт асуух гишүүн байна уу? Тийм. Наранбаяр гишүүнээр тасаллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт болон хамт дагаж өргөн мэдүүлсэн бүх хуулиудын зүйл тус бүрээр санал хураалт явуулна. Ерөнхий хуулийнхаа 10 зүйлтэй байх юм, 10 зүйл тус бүрээр холбогдуулан санал асуулт, зарчмын зөрүүтэй саналууд явна. Тэгээд дагаж байгаа хуулиуд руугаа орно. Тэгэхээр Ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүдийг сая асуугаад Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүнээр тасаллаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Ажлын хэсэгт 2 зарчмын зөрүүтэй санал хүргүүлсэн байгаа. Тэгээд ямар байдлаар тусгагдсан бэ гэдгийг тодруулж асууя? Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Ялангуяа энэ оюутан залуучууд Монгол Улсын хувьд хүн амын нэлээдгүй хувийг эзэлж байгаа энэ оюутан залуучуудтай холбогдолтой асуудлыг Их Хурлын гишүүд болон ЗГ-ын түвшинд хэд хэдэн төслүүд яваад ингээд нэгтгэгдэж батлагдах гэж байна. Монгол Улсын хэмжээнд бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутан залуучуудыг цагийн ажил хөдөлмөрөөр дэмжих ийм зохицуулалтыг оруулж ирж байгаад талархалтай байгаа. Гэхдээ энэ насаар зааж байгаа ийм хувилбараар оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр их сайн анхаарах зүйлүүд байна. 15-аас 22 насаар хязгаарлахаар үндсэндээ бид бүхний дээд боловсролын тогтолцоо бүх сургууль зөвхөн 4 дүгээр курс төгсөөд төгсөж байгаа тийм агуулга байхгүй байна. Ялангуяа 5 дугаар дамжаанд нийтдээ 2025-аас 26 оны хичээлийн жилд 4542 оюутан суралцаж байна. 6 дугаар дамжаанд 2266 оюутан суралцаж байна. Тооны хувьд нөгөө төдийлөн өндөр биш. Гэхдээ яалт ч үгүй оюутан уу гэвэл оюутан, цагийн хөдөлмөр эрхлэх шаардлагатай юу гэвэл шаардлагатай. Энэ тодорхой нийгмийн даатгалын хөнгөлөлтийн боломжийг ялангуяа төгсөх курсийн оюутнууд руугаа чиглүүлэх нь илүү үр өгөөжтэй байна. Анагаахын их сургууль, МУИС, ШУТИС, ХААИС-д үндсэндээ 6 жилээр сурч байгаа 3 мэргэжил байна, 5 жилээр сургаж байгаа 7 мэргэжил байна. Тэгэхээр үүнтэй холбогдолтой зохицуулалтуудыг яаж нэмж тусгасан бэ?

Миний зарчмын зөрүүтэй санал 15-аас 22 гэснийг 5, 6 дугаар курсийнхнийг оруулаад яг энэ бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутан гэдгийг нь үндсэндээ тодорхойлоод, 15-аас 24 болгож нийт оюутнуудаа бүгдийг нь хамруулъя гэсэн ийм агуулга байгаа юм. Тэгэхээр хуулийн төслийн үзэл санаа болон гол энэ оюутан залуучуудаа дэмжье гэдэг агуулгыг илүү хүрээг нь жоохон нэмэх талаас нь оруулсан. Тийм, энэ дээр хариулт авъя.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа хариулъя.

Х.Булгантуяа: Ганхүлэг гишүүний саналыг сая ажлын хэсэг дээр санал хураалт явуулж дэмжигдсэн байж байгаа. Ганхүлэг гишүүний санал маш зүйтэй санал. Бид Засгийн газраас өргөн барихдаа насыг нь 15-аас 22 насных гэж тооцож авч үзсэн байсан. Тэгээд яг Ганхүлэг гишүүний хэлж байгаа 1 дүгээрт Анагаахын оюутнуудаас авхуулаад 5 жил сурч төгсдөг оюутнууд байна. Тэгэхээр хамрагдах боломж нь хязгаарлагдчихаар байсан.

2 дугаарт, ялангуяа эмэгтэй оюутнуудын хувьд дундуур нь төрж, декрет аваад үргэлжлүүлээд сурах ч байдаг юм уу, ийм тохиолдолд энэ эрх нь хязгаарлагдчихаад байсныг 15-аас 24 болгож нэмсэн. Үүнтэй холбоотойгоор төгсөөд 25 насандаа хэрэв хүсэх юм бол тэтгэврийн шимтгэлээ нөхөж төлөх эрх зүйн орчин нь Засгийн газраас өргөн барьсан хууль дээр байсныг 24 нас болгож нэмсэнтэй холбоотойгоор 26 нас болгож нэмсэн байж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл 24 нас хүртлээ сураад энэ тэтгэврийн шимтгэлийн чөлөөлөлтөөс хөнгөлөгдчихөөд, дараа нь өөрөө хүсэх юм бол ажлын байран дээр гараад, үүнийгээ нөхөн төлөх эрх зүйн орчин нь бий болж байгаа гэсэн үг.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хуулийн төслийн гол юу байгаа нь энэ сайн дураараа өөрсдөө оюутнууд өөрсдөө сайн дураараа төлөөд ч явж болно, төлөхгүй явж болно, буцаагаад дахиад 25 нас хүртэлхээр үндсэндээ төсөл нь орж ирсэн. Үүнийг зарчмын зөрүүтэй санал дээр бид 28 болгочихвол яасан юм бэ? Ажлын байран дээр гараад тодорхой 2-оос 3 жилийн хугацаанд буцааж төлөх хэмжээний мөнгөн хуримтлалуудыг бий болгох шаардлагатай. Тийм учраас илүү бодитой байлгах үүднээс, нөгөө талдаа нийгмийн даатгалаа буцааж төлөх тэр хүсэл эрмэлзэл, тэр оролдлогыг нь дэмжих үүднээс бүр 28 болговол яасан юм бэ гэдэг ийм саналыг 2-т нь өгсөн байгаа юм. Тэгээд энэ дээр ажлын хэсэг яаж ярилцсан бэ гэдгийг тодруулъя?

Мөн дээрээс нь дахиад нэг зүйлийг бид үлдээж магадгүй байгаа юм. Гадаад улсаас Монгол Улсад суралцаж байгаа оюутнуудын хувьд энэ зохицуулалтыг ер нь бид яаж харах вэ? Нийтдээ үндсэндээ 4355 оюутан гадаад улсаас Монгол Улсад суралцаж байгаа юм байна лээ. Эдгээр оюутнууд ер нь Монголын оюутнууд гадаадад очихоороо яг бусад оюутнуудтайгаа адилхан цагийн хөдөлмөр эрхлэх нарийн зохион байгуулалтдаа ороод, тэгээд нэмэлт орлогоо олоод явах ийм боломж нь нээлттэй байж байдаг. Харин Монголд байгаа энэ 4300 гаруй оюутан байна, үүний 980 орчим нь болохоор бакалаврын түвшинд суралцаж байгаа юм байна. Тэгэхээр дийлэнх нь магистр, докторт суралцдаг юм байна. Тэгэхээр цаашдаа энэ гадаадаас суралцах оюутнуудыг бид илүү дэмжих, энэ дэлхийн хэмжээний боловсролыг Монголдоо эзэмшүүлэх энэ хандлагуудыг дэмжих нэг шалгуур нь хичээлийнхээ хажуугаар нэмэлт цалин хөлстэй байх, орлоготой байх гэдэг агуулга чухал, тэгээд энийг ажлын хэсэг дээр болон хуулийн төсөл санаачлагчид яаж харсан бэ гэдгийг асууя.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу?

Х.Булгантуяа: Манай яамнаас нэмээд хариулчхаарай. Энэ ажил хөдөлмөр эрхэлж байх хугацаандаа оюутнуудын хувьд бүтэн цагаар бакалаврын болон дэд бакалаврын мэргэжил, зэрэг хамгаалахад энэ хөнгөлөлт, чөлөөлөлт байгаа. Үүний дараа тэтгэврийн шимтгэлийг нөхөж төлнө. Яг бодит байдал дээр гэхэд, үнэнийг хэлэхэд дөнгөж 20 хэдтэй залуучууд 50, 60 хүрээд тэтгэвэрт гарна, би тэтгэврийн шимтгэлээ ахиухан шиг төлчихье гэдэг ийм харилцаанд орох магадлал маш бага. Ер нь Монголчууд тэтгэврийн нас руу дөхөхөөрөө, 45 болон түүнээс дээш ч байдаг юм уу, 50-аас дээш насанд л тэтгэврийн асуудалд онцгой ач холбогдол өгч, анхаарч эхэлдэг. Тэгэхээр яах вэ үүнийг эрх зүйн хувьд нээж өгөх нь зүйтэй. Гэхдээ хойш нь хэтэрхий их тавихаар хэд хэдэн хүндрэлүүд үүсэх магадлалтай.

1 дүгээрт, бүр 10 хэдэн насандаа авсан нөгөө хөнгөлөлт, чөлөөлөлтийг буцаагаад төлөхөд инфляцын түвшинтэй уялдуулж энэ тэр төлөх нөхцөл байдал үүсвэл энэ нэлээдгүй өндөр болоод нөгөө шимтгэл төлөгч дээр орж ирнэ гэсэн үг. Энэ дээрээс нь нэмээд хүн болгон адилгүй. Бид нөгөө үйлдвэрлэлийн ослын шимтгэл, ажил олгогчийн төлсөн байдлаар Монголын бүх бакалаврын оюутнууд ажил хөдөлмөр эрхлэхгүй байх, ажил хөдөлмөр эрхэлсэн мэдээлэл бидэнд байна нийгмийн даатгалын байгууллагад, тэр мэдээлэл дээр үндэслэж төлнө гэсэн үг. Гадаад оюутнуудын хувьд ажлын хэсгээс нэмээд хариулаадхаач, тэгэх үү? 3 номер хариулах уу, 2 номер ажлын хэсэг.

П.Ганзориг: Ажлын хэсгийн 2 номер.

Б.Батжаргал: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя, НДЕГ Батжаргал. Гадаад оюутны хувьд олон улсын нийтлэг жишиг нь нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрээрээ зохицуулагддаг. Одоогийн байдлаар манай Монгол Улс нийтдээ 8 улстай нийгмийн хамгааллын хэлэлцээртэй. Энэ ямар агуулгатай вэ гэвэл жишээлбэл Унгар улсад манай Монгол оюутан сурч байгаа, тэнд нийгмийн даатгал төлөх юм бол тэр төлсөн шимтгэлийг нь Монгол Улсад тэтгэвэрт гарахад нь ашиглагддаг ийм зарчмаар явж байгаа. Тэгээд одоогийн байдлаар манай улс 9 дэх улс буюу Австрали улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тэгээд яах вэ буцаан төлөх бололцоо, тэр насны хязгаарыг нь жоохон тавиад өгвөл нийгмийн даатгалын санд орж ирэх санхүүжилт нь нэмэгдэх болов уу гэдэг талаас нь хараад байна л даа. Тэгээд манай мэргэжлийнхэн яг үндсэндээ 1, 2 жилийн хугацаанд энийг жоохон нэмээд өгөхөөр ямар яг сөрөг зүйлүүд гарах вэ гэдэг дээр дахиад нэмж тодруулж өгөөч? Миний харж байгаагаар яг тэтгэврийн энэ даатгалаа буцааж төлөх нэг жил байх, 2 жил байх, 3 жил байх хоёрын хооронд төдийлөн нэг их зөрөө байхгүй байх. Гэхдээ яг нөгөө нэг оюутан залуучуудын маань хувьд жил ажиллаад хуримтлуулах боломж энэ тэр гэдгийг яг хувийн талаас нь харах юм бол их тийм чухал асуудал байгаад байгаа юм. Гадаад оюутны хувьд энэ тооцоололд орох уу, энэ эрхийг үндсэндээ авах уу, гадаад оюутан Монголын ААН-үүд дээр цагийн хөдөлмөр эрхлэхэд энэ нийгмийн даатгалын энэ зохицуулалтыг авах уу гэдэг ийм асуулт байгаа. Энэ дээр та хэд тодорхой хариулж өгөөч?

П.Ганзориг: Ажлын хэсгээс хариулах уу? Хэн хариулах вэ? 2 номер.

Б.Батжаргал: Ганхүлэг гишүүний тодруулгад хариулъя, НДЕГ Батжаргал. Гадаад улсын иргэний хувьд энэ хөнгөлөлт чөлөөлөлтөд орохгүй, энд зөвхөн Монгол Улсын иргэн оюутан хамаарагдана. Яагаад 28 нас гэж тавихгүй байна вэ гэхээр ер нь 26 наснаас урагшаа 1 жил, 2 жил, 3 жил, 4 жил гэсэн ийм боломжтой хугацааныхаар төлөхөөр болчихлоо. Тэгээд тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс төлөх учраас ийм нэг том ачаалал болж орж ирэх магадлалтай. 2 дугаарт гэвэл манай улс яг хуваарилалтын аргачлалтай санхүүжилтийнхээ хувьд, тэгээд бид энэ хэт хойшоо энэ төлөлтийг аль болох тавих зохимжгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр аль болох тэр 26 насан дотроо бариад, тэр нь үйлдвэрлэлийн ослын даатгалаар тайлагнасан хугацааныхаа тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээсээ төлөөд явна гэсэн ийм зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя.

Х.Булгантуяа: Манай нийгмийн даатгалын зарчим нэг ийм байх ёстой, нөхөн төлөлтийг бид аль болохоор хязгаарлах ёстой гэдэг зарчмыг баримталдаг. Яагаад гэвэл даатгал гэдэг чинь эрсдэл үүсэхээс нэлээн эрт өөрөө өөрийнхөө нийгмийн баталгааг хангахын төлөө цалин орлоготой байхдаа төлөх ёстой. Тэгэхээр сая Үйлдвэрчний эвлэлээс ингээд хэд хэдэн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийж байгаа

ч гэсэн үнэнийг хэлэхэд энэ нөхөн төлөх харилцааг бүр дэмжмээргүй байна гэдэг саналууд маш их гарсан. Яах вэ бид ажлын хэсгээс 1 дүгээрт хэд хэдэн гишүүд, Ганхүлэг нарын гишүүд өргөн барихаар энэ хуулийн төслийг бэлдчихсэн байгаа, Шижир нарын гишүүд хуулийн төслийг өргөн барьсан байгаа гэх мэтчилэн эдгээр зүйлүүд нь угаасаа оюутнуудын цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс байж болох зохицуулалт.

Гэхдээ нөхөн төлөх хугацааг хэтэрхий хойш нь тавиад ингээд нөгөө талдаа сан дээр ачаалал үүсгэх энэ эрсдэлийг бууруулах нь зүйтэй. Нөхөн төлөлтийг хэтэрхий их цаг завын хувьд ийм боломжтойгоор олгох нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн ерөнхий зарчим дээрээ жоохон юугүй байгаад байна. 28 настай хүн ер нь аль хэдийн шимтгэл төлөгч болоод эхэлчихнэ. Энэ чинь бараг ахиад нийт тэтгэвэрт гарах насныхаа талд нь хүрчхэж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр бид аль болохоор шимтгэл төлөлт тухайн үед бараг албан журмын шимтгэл төлөгч болчихсон байх байх гэж харж байгаа юм.

П.Ганзориг: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг ингээд гишүүд санаачлаад Түвшин гишүүн, Ариунзаяа гишүүн, мөн Засгийн газраас санаачилж оруулж ирсэн энэ 3 хуулийн төслийг нэгтгэж ингэж оруулж ирж байгаа ажлын хэсэгт юуны түрүүнд талархал илэрхийлье.

Нэлээн суурь шинжтэй, нэлээн НДШ төлөгчдөө ээлтэй иймэрхүү заалтууд орж ирж байгаа юм байна. Ер нь жишээлэх юм бол энэ дээр хэлэхэд, нэг ажил олгогчийн нийт НДШ-ийн ачааллыг бага зэрэг бууруулахын зэрэгцээ яг шинэ, жижиг, дунд бизнес эрхэлж байгаа ийм хүмүүст ээлтэй нэг заалт байгаа нь 5 хүртэл ажилтантай ажил олгогчийн 3 хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх шимтгэлийг тодорхой төрлөөс нь 36 сар хүртэл хугацаанд чөлөөлөх боломжтой болох юм байна. Тэгэхдээ энэ дээрээ нэг нөхцөл тавьсан байна, НДШ-ийг сүүлийн 5 жилд бүрэн төлсөн ийм тохиолдолд гэж. Тэгэхээр сүүлийн 5 жил шимтгэлээ бүрэн төлсөн гэдгийг ямар шалгуураар үнэлж байна, жижиг хэмжээний хугацаа хэтэрсэн өр үүнд нь хамаарах уу гэдэг нэг ийм асуулт байна?

2 дугаарт нь энэ ажил олгогчийн төлөх шимтгэлийн бүтцэд орж байгаа өөрчлөлт. Энэ нь болохоороо үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь. Энийг бууруулж байгаа юм, 0.5, 1.5, 2.5 байсныг 0.3, 1.0, 1.5 болж бууруулж байна. Харин ажилгүйдлийн даатгалын шимтгэл 0.5-аас 0.6 болж өсөж байгаа юм байна. Тэгэхээрээ энэ дээр энэ үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийг бууруулснаар тухайн сангийн орлого хэр хэмжээгээр буурах вэ? Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлж байгаа үндэслэл нь яг юу юм бэ? Нийт шимтгэлийн хувь буурснаар энэ нийт шимтгэлийн хувь 1 орчим хувь буурахаар байна лээ л дээ. Ингэснээр нийгмийн даатгалын сангийн алдагдлыг хэрхэн нөхөх гэж байна вэ? Энэ асуудлыг энэ сонсож байгаа хүмүүс тайлбарыг авах хэрэгтэй гэж бодож байгаа учраас асууж байна.

Даатгуулагчийн шимтгэлийн нэг хувийг хуримтлалд ингээд шилжүүлнэ гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээрээ өнөөдөр ингээд өөрөө өөрийгөө авч явах хэмжээнд хүрч чадахгүй байгаа нийгмийн даатгалын энэ сангийн маань өөрийнх нь энэ нөхцөл

байдал ямар болж хувирах вэ? Одоогийн эв санааны нэгдлийн энэ тэтгэврийн сангийн орлогод ямар нөлөө үзүүлэх вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Тэгээд 3 дахь асуулт нь энэ Засгийн газар өөрөө бэлэн үү? Өөрөөр хэлбэл 2027 оны 1 сарын 1-нээс ингээд хэрэгжээд эхлэх гээд байна. Гэтэл энэ дээр мэдээж энэ элдэв орлогуудыг ингээд чөлөөлж хөнгөлж байгаа учраас үлдсэн энэ дээр нь хэрхэн компенсаци гэх юм уу нөхөн төлбөр гэх юм уу энийг нь хийж явах юм бэ. Улсын төсвөөс 50 хувийн урамшуулал олгоход улсын төсөв нь өөрөө бэлэн үү, 5 хүртэл ажилтантай ААН-д олгох шимтгэлийн хөнгөлөлтийн төсөвт үзүүлэх нийт ачааллыг тооцно уу гэсэн 1 ийм асуулт байна? Тэгээд ер нь бид.../минут дуусав/

П.Ганзориг: Наранбаяр гишүүн нэмэлтээр тодруулъя.

П.Наранбаяр: Тэгээд ер нь бид нэг зүйлийг анхаарах нь энэ ер нь 2, 3 зүйл байна. 1 дүгээрт, энэ ажил олгогчийг дэмжих асуудал байгаа. Ажил олгогч дээр ирж байгаа ачаалал маш их байгаа шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа татварын ер нь НДШ-ийг оролцуулаад бараг 40 хувь гараад явчихдаг. Гэтэл хувьцаа эзэмшигч өнөөдөр 5 юм уу, 10 хувийн л ийм юу төлж байгаа шүү дээ. Хэнд ч ажил олгохгүй, өөрөө бизнес эрхлэхгүй зүгээр хөрөнгө оруулаад хувьцаа эзэмшээд явж байгаа хүмүүст өгч байгаа энэ татварын ачаалал Монгол Улсад ийм байгаа. Гэтэл өөрөө ажил олгогч болж байгаа ийм үед НДШ-ээс авхуулаад энэ ажил олгогч нарыг олон талаас нь энэ татварын дарамтад оруулж ирсэн ийм гашуун түүх байгаа шүү. Ийм учраас бид энэ ажил олгогчдыг дэмжихэд НДШ-ийн энэ бодлогыг чиглүүлэх хэрэгтэй. Залуусыг дэмжиж байгаа нь маш сайн байна. Оюутнуудыг цагийн ажил эрхлэхэд нь НДШ-ыг сонголтоор өгөх боломжийг олгож байгаа.

Нөгөө талдаа энэ залуучуудад олгож янз бүрийн хөнгөлөлт юмнууд жишээлбэл автобусны ч юм уу, оюутнуудад олгож энийг бид больчихмоор байгаа юм. Больсон байгаа юу? Тэгэхээр энэ бол их зөв бодлого. Цаашдаа ерөөсөө хөдөлмөрлөж орлогоо олж байж л явна гэдэг залуу үеийг ингэж хүмүүжүүлж, ингэж энэ чиглэл рүү нь чиглүүлэх нь зүйтэй байна гэж харж байна.

ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан энэ олон тулгуурт тэтгэврийн тогтолцоо, хуримтлалын тэтгэвэр эд нар гээд энэ тогтолцоонууд ингээд орж ирж байгааг бид дэмжиж байгаа. Үүнтэй холбоотойгоор Хувийн тэтгэврийн сангийн хууль орж ирж байгаа. Тэгээд энэ болгон дээр бид дэмжээд явж байгаа. Харин энэ баланстай байх ёстой гэдгийг л бид олон талаас нь харж, мэргэжлийн энэ улсууд, экспертүүд нь, энэ мэргэжлийн яам нь энэ дээрээ мэдээллийг маш УИХ-д сайн өгч яваарай гэдгийг хэлэх гэсэн юм. Асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Булгантуяа: Наранбаяр гишүүн маш зөв асуудлуудыг хөндөж байна. Ажилгүйдлийн тэтгэмж нэг ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм байна. Сүүлийн үед манай ажилгүйдлийн тэтгэмжийн сангийн орлого нь зарлагаа гүйцэхээ байсан. 2025 онд гэхэд 162,7 тэрбум төгрөг ороод, 203,3 тэрбум төгрөг зарлагдсан байна. Ингээд 44,5 тэрбум төгрөгийн алдагдалтай. 2023 онд гэхэд 48,4 тэрбум төгрөг. Бид 1995-аас 2013 оны хооронд ажилгүйдлийн тэтгэмжийг ажил олгогч даатгуулагч 2 аль аль талаасаа 0,5 0,5 гээд нэг хувийг төлдөг байсныг 2013 оноос 0,2 даатгуулагч талаас 0,2 болгоод, ажил олгогчоос ч гэсэн бууруулчихсан байсан. Энийг буцаж

нэмээд 0,7 хувь болгосон байсан, тэгээд 0,7 хувь ч үнэндээ хүрэлцэхгүй байгаад байгаа юм.

Харин манай үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шимтгэл, түүнээс бүрдэж байгаа сан харин эсрэгээрээ их өндөр чөлөөт үлдэгдэлтэй. ХАБ-ын хууль үүнтэй холбоотой зарцуулалт их хэцүү. Нэг сургалт мэдээлэл, сурталчилгаа тиймэрхүү л зүйлүүд хийх юм байна лээ, судалгаа энэ тэр л хийхээс илүү гарч чадахгүй. Тэгэхээр бараг 200, 300 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй сан бий болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ шимтгэлийг бууруулаад, ажилгүйдлийн тэтгэмжийг нь харин арай жоохон нэмээд, яг ажил олгогч дээрээ энэ нь нийт төлөх дүнгийн хэмжээг харин жоохон бууруулах энэ арга хэмжээг бид авсан.

ЗГ бэлэн үү гэж байна. ЗГ өөрөө дэмжиж, Сангийн сайд нь, Хууль зүйн сайд нь бүгдээрээ дэмжиж гарын үсэг зурж, УИХ-д өргөн барихыг дэмжсэн юм чинь би хэрэгжүүлэхэд бэлэн л гэж бодож байгаа юм. Тэгэхдээ ер нь ийм том хэмжээний реформ хийх хэрэгцээ шаардлага байсан уу гэвэл байсан. 1994 оноос бид нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоо руу шилжиж эхэлснээс хойш 2023 онд нийгмийн даатгалын 4 том хуульд өөрчлөлт ороод нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлтийг хийсэн. Ингээд тэр үед ер нь энэ нийгмийн даатгалын том өөрчлөлтийг хийхэд Ерөнхий сайдын өөрийнх нь зүрх зориг л их хэрэгтэй байдаг юм байна лээ. Тэрнээс биш Сангийн сайд нь мөнгө өгөхгүй боломжгүй шүү дээ гээд л байвал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд ганцаараа гүрийгээд, гүрийгээд нөгөө нэмэгдэхүүний байрыг солигдохоор нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй ийм л байдалтай байгаа.

Тэгэхээр нэмэгдэхүүний нийлбэрийн чанарыг өөрчлөх хэмжээний өөрчлөлтийг энэ удаа Засгийн газар оруулж чадсан, 2023 онд ч гэсэн үүнийг нэлээдгүй зоригтойгоор хийж чадсан. Инфляцтай уялдуулж жил болгон нэмэгддэг болсон, гэр бүлийн нэг гишүүнд нь, гэр бүлийн 2 хүний нэгэнд нь өвлөгддөг болсон гэх мэтчилэн энэ зохицуулалтыг хийнэ гэдэг тийм амархан ерөөсөө байдаггүй. Тэгээд энэ удаа Ерөнхий сайд, ялангуяа таны хэлж байгаа олон тулгуурт, тэгээд дээрээс нь нэмээд 1.5 хувийг хуримтлуулъя, мөнгөжүүлье энэ тэр гэдэг бол ялангуяа ирээдүйн залуучуудын шимтгэл төлөгчдөд маш их таалагдах үзүүлэлтүүд болох гэж байгаа юм. Шинээр шимтгэл төлөгчид бид тооцож үзэхэд тэтгэвэрт гарахад 200 гаруй сая төгрөгийн 1 аравны зөвхөн.../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгээс хариулах уу, нэмж? Ажлын хэсгийн хэдэн номер вэ? 2 номерын микрофон.

Б.Батжаргал: Наранбаяр гишүүний асуултад хариулъя, НДЕГ Батжаргал. 1-ээс 5 хүртэл ажил олгогчтой ажил олгогчийн 3 хүртэл ажилтныг НДШ-ээс чөлөөлөх зохицуулалтын хувьд тухайн байгууллага нь нийгмийн даатгалын байгууллагад, ажил олгогч нь нийгмийн даатгалын байгууллагад НДШ төлөлтийн тайлан буюу НД-7, НД-8 тайлангаа тухайн хугацаанд нь хүргүүлж ирүүлчихсэн, манайд регистр бүртгэлтэй байх ёстой гэсэн ийм шаардлага тавьж байгаа. Үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн хувьд одоо ажлын байрны эрсдэлээс хамааруулаад 0.5, эсвэл 1.5, эсвэл 2.5 гэсэн ийм хувиар төлж байгаа. Жишээлбэл, уул уурхай 2.5 гэсэн хувиар төлдөг.

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг анхаарах шаардлагын үүднээс 0.1 хувийг дотор нь гүйлгээд, үйлдвэрлэлийн ослоос ажилгүйдлийн даатгалын сангийн ажил олгогчийн төлөх хувь дээр 0.1 хувийг шилжүүлэн тооцож байгаа. Энэ тооцооллоо оруулаад 0.5, 1.5, 2.5 байсныг одоогийн хуулийн төсөл дээр 0.3, 1.2, 2.2 гэсэн ийм хувилбараар төлөх ийм хувилбарыг боловсруулсан байж байгаа. Одоогийн үйлдвэрлэлийн ослын даатгалын сангийн үлдэгдэл нэлээн боломжийн үлдэгдэлтэй байдаг учраас энэ бууралтын 41 тэрбумын бууралтын ачааллыг энэ сан цаашид аваад явах боломжтой байна гэж үзсэн. Баярлалаа.

П.Ганзориг: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Баатархүү гишүүн, Болормаа гишүүн, Галбадрах гишүүн санал хураалтдаа бэлтгэе. Хэрлэн гишүүн ороогүй байна, Сарнай гишүүн ороогүй байна. Ганмаа гишүүн байна уу? Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийн “хоёр хүртэлх гэрээнээс сонгон” гэснийг “нэг гэрээнээс” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Х.Булгантуяа, Ц.Баатархүү, Р.Батболд, С.Зулпхар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат цаашид ажлын хэсэг гэх. Үүн дээр мөн нэмэгдээд УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин гишүүний гаргасан санал адил агуулгатай тул нэгтгэгдэж санал хураагдаж байгаа. Ингээд энэ саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 57.1 хувиар дэмжигдлээ. Батнайрамдал гишүүнийг дэмжсэнээр авъя.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн “15-22” гэснийг “15-24” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, мөн УИХ-ын гишүүн Ганхүлэгийн санал энэ дээр нэгтгэгдэж санал хураагдаж байгаа юм байна. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 76.2 хувиар дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “25” гэснийг “26” гэж өөрчлөх. Энэ тайлбартай юм байна, 1 дүгээр санал дэмжигдсэн тул энэ 2 дугаар саналыг хураалгах юм байна. Санал хураалт санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 76.2 хувиар дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. 30 сар хүртэл хугацаанд юм байна шүү. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл энэ

чөлөөлөлтөд хамаарна. Энэ ажил олгогчийн шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.”

Тайлбар:Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно гэж байгаа юм байна. Энийг санал гаргасан ажлын хэсэг байгаа. Мөн Саранчулуун гишүүний гаргасан саналуудын 21.29 дэх саналын томъёолол ижил агуулгатай тул нэгтгэж ингэж оруулж санал хураагдаж байгаа юм. Тийм ажлын хэсэг дээр 60 болгочихсон юм биш үү нэгтгээд яриад, тэгээд саналаа нэгтгэж оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Энэ дээр ажлын хэсгийн ахлагчид тайлбар хэлэх үү нэмэлт. 60 гээд орчихсон бол шууд санал хураалгалаа шүү. Ингээд саналыг нэгтгэсэн тул энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс” гэсний дараа “доошгүй орлогоос” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. 1 дүгээр зүйл ерөнхийдөө санал хураагдаад ингээд сүүлийн санал хураалт бол Саранчулуун гишүүн тодруулах зүйл байгаа гэсэн. Энэ дээр тодруулах уу, асуулт байгаа юм уу, санал байгаа юм уу, байхгүй юу? Гаргасан саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан УИХ-ын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. УИХ-ын гишүүн С.Цэнгүүнээс ирсэн зарчмын зөрүүтэй санал. 7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их, дээд сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч, мөн тухайн насны бүтэн бус цагийн ажил эрхэлж буй ажилтан өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно. Санал гаргасан УИХ-ын гишүүн С.Цэнгүүн. Санал хураалт. Ажлын хэсгээс тайлбар хийе, ажлын хэсгийн ахлагч.

Х.Булгантуяа: Үүн дээр оюутнуудынх угаасаа түрүүн та бүхэн маань дэмжээд дэмжигдчихсэн явж байгаа, 15-аас 24 насных гээд бакалаврын болон дэд бакалаврын оюутнуудынх дэмжигдсэн байгаа. Үүн дээр ингээд ийм насны бүх хүмүүс гэхээр ялангуяа Үйлдвэрчний эвлэлээс үүн дээр маш их шүүмжлэлтэй хандсан. Залуучуудын хувьд ажил хөдөлмөр эрхэлж байгаад янз янзын эрсдэлд орох, дээрээс нь нийгмийн баталгаа нь алдагдах энэ үүд хаалгыг нээнэ шүү. Энэ насныхан эсхүл суралцах ёстой, хэрвээ ажил хийвэл албан журмын даатгалд байдаг юм уу л гэхээр сайн дураараа шимтгэл төлөөд нийгмийн баталгаагаа хангах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг баримталж байгаа. Тэгэхгүй эсрэгээрээ энэ насны оюутнуудын хувьд нийгмийн баталгаа нь алдагдана, дараа нь жишээлбэл тэтгэвэр тэтгэмж, ингээд үйлдвэрлэлийн осол гэх мэтчилэн эдгээр нь бүгдээрээ алдагдах эрсдэлтэй байгаа гэж манай нийгмийн даатгалаас, дээрээс нь Үйлдвэрчний эвлэлээс үзсэн байж байгаа, Тэгэхээр та бүгдийг энийг дэмжихгүй байхыг хүсье.

П.Ганзориг: Ажлын хэсгээс тайлбар хийлээ. Ингээд Цэнгүүн гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 3 гишүүн дэмжиж, 14.3 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн гишүүний санал, саналын томъёоллыг уншиж танилцуулъя. “21.29.Эхний 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа гарааны бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.” УИХ-ын гишүүн Б.Пунсалмаа гэсэн ийм саналын томъёолол байна. Ажлын хэсгээс тайлбар байгаа юу? Ажлын хэсгийн ахлагч тайлбар хийе.

Х.Булгантуяа: Пунсалмаа гишүүн түрүүлээд тайлбараа хийчихье, тэгэх үү? Би тэгээд араас нь хийчихье.

П.Ганзориг: Пунсалмаа гишүүн тайлбар хийе. Пунсалмаа гишүүний микрофоныг нээе, бүртгэл нь орсон уу?

Б.Пунсалмаа: Төрийн бодлого үндэсний томоохон татвар төлөгч ААН-үүдийг бүрдүүлэхэд л байдаг юм. Гэтэл энэ хуулиар 5-аас ихгүй ажилтантай ажил олгогчийн 3 хүртэлх ажилтныг нь ажил олгогчийн нийгмийн даатгалыг нь хөнгөлөх гээд байгаа юм. 5 хүртэлх ажилтантай гэхээр энэ үндэсний томоохон ААН-үүдтэй болох гээд энэ төрийн бодлого явж байхад энэний эсрэг бодлого явчхаж байна. Энэ бүх ААН-үүд чинь 5 хүртэлх ажилтантай болох ийм заалт орж ирж байгаа буюу компаниуд хөнгөлөлт эдлэхийн тулд 10 ажилтантай байвал магадгүй 2 компани бүртгүүлээд ингээд маш олон жижиг компаниуд бий болох, энэ үндэсний томоохон татвар төлөгч бүрдэх энэ боломжийг нэлээн сааруулсан ийм заалт орж ирэх гэж байна. Тэгээд энэ чинь энэ компаниудад, тэгээд иргэний улсын бүртгэл дээр баахан олон компаниуд бүртгэгдээд байдаг, нягтлан бодох бүртгэл дээр нэлээн ачаалалтай ийм сайн биш заалт орж ирэх гэж байна. Тийм болохлоор энийг ерөөсөө эхний 3 жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа start up компаниудаа дэмжээд бүхэлд нь ажил олгогчийн төлөх НДШ-ийг нь хөнгөлөөч гэсэн энэ саналыг хүргүүлж байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс нэмэлт тайлбар хийе. Ажлын хэсгийн ахлагч.

Х.Булгантуяа: Бид уг нь сая энэ ажлын хэсэг дээр үүнийг нэлээн аминдаа хумьж өгсөн юм. Энэ жишээлбэл нэг хүн нэг компани байгуулаад л, эсхүл нэг хүн нэг компаниас нөгөө компани руу очоод л нөгөө компанидаа шимтгэлээс чөлөөлөгдөх боломжийг нь нээж өгөөд байж болохгүй юм гээд нэг хүн шимтгэл төлөлтийнхөө нийт хугацаандаа ганцхан удаа энэ боломжид хамрагдана гээд. Тэгэхээр энэ 1 дүгээрт харьцангуй бид хааж өгсөн байж байгаа.

2 дугаарт яах вэ манай 143 мянга орчим ААН-үүдээс, 63 мянга орчим ААН-үүдээс 1-ээс 5 ажилтантай ААН нийтдээ 40 хувь байна. Тэгэхээр үүнийг ганцхан start up гэхээр нөгөө start-up-н хуулийн заалт манай Баатархүү гишүүн юун дээр хэлж байсан ажлын хэсэг дээр аягүй нарийн заалттай. Харин үүн дээр өрхийн жижигхэн бизнес эрхэлж байгаа хүмүүс ч гэсэн орж болно. Нөгөө саван эрхэлдэг ч байдаг юм уу, жижиг хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг ч байдаг юм уу, хүмүүсийг 1-ээс 5 хүнтэй байсан ч гэсэн жижиг бизнес эрхлээд ажилчдынхаа НДШ-ийг төлөөд, эсхүл би өнөөдөр 2 ажилтантай байж байгаад ахиад нэмээд 2 хүн нэмээд авах юм бол түүн

дээр ажлын байр шинээр бий болгож байгаа дээр нь ажил олгогч дээр нь нэмэлт нийгмийн даатгалын дарамт үзүүлэхгүй гэж энэ хуулийн зүйлд энэ зохицуулалтыг хийж өгсөн.

Start up гээд ингээд хязгаарлачихаар Start up зохицуулалт нь Пунсалмаа гишүүн аягүй чанга юм билээ 1 дүгээрт. 2 дугаарт аль хэдийн бизнес хийгээд тодорхой хэмжээний ачаалал үүрээд ингээд мачийгаад байгаа компаниуд дээр бид жоохон дэмжлэг үзүүлэхгүй бол цоо шинэ байвал л дэмжинэ гэхээр нөгөө тогтворжих гэж ядаж байгаа хэдэд маань юутай юм болов уу. Хэтэрхий задгай тавих юм бол таны хэлж байгаа үнэн. Энэ жижгэрэх магадлалтай. Тийм учраас бид нэмж нэг ажилтан үүнд нэг л удаа хамрагдана гэх мэтчилэн ийм зохицуулалтыг хийж өгсөн. Үүсгэн байгуулагчаар хийх гэхээр хэцүү юм билээ энийг барихад 10 хувийн хөрөнгө оруулагч ч байж болно, зарим дээр нь 50 хувь, 100 хувь ч байж болно. Тэгээд ингээд хэтэрхий их нөгөө overhead менежмент зохицуулалт нь их тийм амаргүй болж магадгүй гэж үзээд энэ хууль дээр зарим хаалтуудыг хийж өгсөн. Баатархүү гишүүн энэ start up зохицуулалтыг ажлын хэсэг дээр ярьж байсан, их төвөгтэй болохоор юм байна лээ.

П.Ганзориг: Пунсалмаа гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 8 гишүүн дэмжиж, санал 38.1 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.30 дахь хэсэгт "Энэ хуулийн 21.29-д заасан ажил олгогчид төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, гадаад улсын олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага хамаарахгүй" гэсэн заалтаас "төрийн бус байгууллага" гэснийг хасах. Санал гаргасан О.Саранчулуун гишүүн байна. Энэ дээр тайлбар байгаа уу? Саранчулуун гишүүн тайлбар хийе.

О.Саранчулуун: Гишүүдээ, энэ дээр ингэх гээд байгаа юм. Түрүүн бид 21.29 дээр сүүлийн 5 жилийн хугацаанд НДШ төлөгчөөр бүртгүүлж байгаа нөгөө ажил олгогчийн шимтгэлийг чөлөөлөх тухай ярьсан шүү дээ. Энгийн хүмүүс 36 сар, хөгжлийн бэрхшээлтэй 60 гэхихсэн. Тэгэнгүүт энэ дээр 30 нь болохоор энэ хуулийн 21.29 дээр заасан дээр төрийн бус байгууллага хамаарахгүй гэхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ төрийн бус гэдгийг нь хасах санал оруулсан юм. Яагаад гэвэл би та бүхэнд 2 тоо хэлье.

Монголд одоо байгаа бүртгэлтэй нийт төрийн бус байгууллагуудын 70 хувь нь дээд тал нь 1-ээс 5 хүртэлх ажилтантай байдаг, яг үндсэн бүртгэлтэй гүйцэтгэгч нийгмийн даатгал 1 дүгээр тоо. 2-т гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажиллаж байгаа ажлын ихэнх, маш олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төрийн бус байгууллагад ажилладаг байхгүй юу. Тэгэхээр нөгөө 21.29 дээр заасан хөнгөлөлтийг чинь, хөнгөлөлт гэх юм уу энийг 30 дээр яг ингээд бодитоор хэрэгжүүлэх гэхээр төрийн бусын хэсэг нь хасагдчихаж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ нь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгийн ихээр ажиллуулдаг тэр төрийн бус байгууллагуудыг дэмжихгүй болохоор яг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой нийцэхгүй л болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр та бүхнийг би дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч нэмэлт тайлбар хийе.

Х.Булгантуяа: Яах вэ төрийн бус байгууллагын асуудлыг бид ажлын хэсэг дээр нэлээн ярьсан юм. Тэгээд улсын хэмжээнд төрийн бус байгууллагын тоо маш өндөр, үүн дээр яг тогтвор суурьшилтай үйл ажиллагаа явуулдаг, явуулдаггүй, дээрээс ажилчдынх нь нийгмийн баталгааны асуудал нь ч гэсэндээ ярвигтай зүйлүүд нэлээдгүй байна. Тэгэхээр би Саранчулуун гишүүнээ ингэж бодоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байгаа юм чинь төрийн бус байгууллагыг чөлөөлье гэдэг нэг тийм нэгдсэн зохицуулалт жоохон зохимжгүй. Энэ дотор яг үнэнийг хэлэхэд төрийн бус байгууллага дотор янз янзын үйл ажиллагаа явуулдаг байна. Жишээлбэл ингэж болох байхгүй юу. Ариунзаяа бид 2 нийлж байгаад нэг эмэгтэйчүүдийн ямар юмыг дэмжих төрийн бус байгууллага гэж байгуулаад л үүн дээрээс тэгвэл энэ хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлэх боломж нь бий болчихоод байгаа байхгүй юу. Өөрсдийгөө энд бүртгүүлээд л ингээд хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлээд яваад байж болно. Наана чинь ямар, ямар юм сонирхогчдын гээд бүх янзын Монголд төрийн бус байгууллага байна.

Нөгөө талдаа хэрвээ яг та хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэх гээд байна гэвэл Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулиар, эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар ч байдаг юм уу зохицуулалтыг хийгээч. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг бид бүхий л талаараа дэмжихэд бэлэн байна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байгаа юм чинь гээд тэнд бүх хүмүүст үүд хаалгыг бид нээж өгч болохгүй гэж бодож байна.

П.Ганзориг: Саранчулуун гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 8 гишүүн дэмжиж, санал 38.1 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 19.5 дахь заалтын "хөлсний доод" гэсний араас "хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна" гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин. Энхтүвшин гишүүн тайлбар хийе үүн дээр.

Д.Энхтүвшин: Энэ заалт болохоор даатгуулагчийн НДШ төлөх дээд хязгаарыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхээр ингээд заачихсан байгаа. Тэгэхээр ажил олгогчийн энэ НДШ төлөх дээд хязгаарыг адилхан болгоё гэсэн ийм санал байгаа. Хуулийн төслөөр болохоор энэ адилхан болгохыгоо 2030 он хүртэл 12-оос 11, 12, 11, 10 гээд 2 жил дараалан 2030 он хүртэл ингээд аажмаар тавьсан ийм зохицуулалт байсныг хоёуланг нь адилхан болгочихъё. Ажил олгогч болон даатгуулагчийн НДШ төлөх дээд хязгаарыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин үржүүлсэнтэй тэнцүү адилхан болгоё гэсэн ийм санал байгаа. Ажил олгогчийн зүгээс НДШ өндөр төллөө гээд яг даатгуулагчид ямар нэгэн дэмжлэг, нэмэр байдаггүй, энэ хэмжээгээр нэмэгддэг тийм орлогууд байхгүй учраас энийг адилтгая гэсэн. Ажил олгогч дээр ирж байгаа ачааллыг 1, 1 хувиар 2 жил ингэж цувуулж байснаас яг ижилхэн цаг хугацаанд тэнцүү болгоё гэсэн ийм санал байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч тайлбар хийе.

Х.Булгантуяа: Бид сая сүүлийн хэд хоног Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч, Олон нийтийн хяналтын зөвлөл гэж байдаг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд, мэргэжлийн холбооныхонтой их ажилласан. МҮЭХ-ноос энэ саналыг бүр 100 хувь эсэргүүцчихээд байгаа юм. Гэхдээ Энхтүвшин, дээрээс нь нэмээд Түвшин нарын гишүүдийн хууль дээр ч гэсэн энэ зүйл, заалт байсан. Тэгэхээр үүнийг бид Засгийн газраас өргөн барьсан хууль дээр авъя, тэгэхдээ зохицуулалтыг нь 2, 3 жилийн хугацаанд багасгаад ингээд 10 жил дээр барихаар, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10, энэнээс илүүгүй гэдгээр энэ зохицуулалтыг нь авъя. Тэгэхгүй бол хэдүүлээ нөгөө талдаа ингэж бодох хэрэгтэй. Бид нийт шимтгэл төлөгч 1.2 сая иргэний төлөө дуугарах ёстой, нөгөө талдаа тэтгэвэр авч байгаа 500 мянган иргэний төлөө дуугарах ёстой, энд бизнес эрхэлж төлж байгаа ААН-ийнх нь төлөө дуугарах ёстой.

Тэгэхээр аль нэг талынх нь эрх ашгийн гэхээсээ илүүтэйгээр энд бид нөгөө талдаа Үйлдвэрчний эвлэлийн холбооны саналыг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн гишүүн гээд ингээд хуульд бүр заагаад, энэ гишүүнчлэл гишүүнээр манай шимтгэл төлөгч, даатгуулагчдыг төлөөлж суудаг байгууллагын саналыг харгалзан үзэж, ийм байдлаар Засгийн газар дээр оруулж ирсэн саналаар явах нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм. Нөгөө талдаа бид нийгмийн даатгалын сан дээр ирж байгаа ачааллаа хэт их юу яахад хэцүү. Түрүүн Наранбаяр гишүүн хэлж байсан, энэ хууль нийтдээ бараг 3 их наяд орчим төсвийн зарлага нэмэгдүүлэхээр хуулийн зохицуулалт байгаа. Шимтгэл төлөгч талдаа ч нэлээдгүй ашигтай, ААН-дээ ч гэсэн нэлээдгүй ашигтай зохицуулалтуудыг тусгаж өгсөн байгаа учраас үүнийг Засгийн газраас өргөн барьснаар нь дэмжиж өгөөч гэж хүсэх гэсэн юм.

П.Ганзориг: Ажлын хэсгээс Эрдэнэбат гишүүн нэмэлт тайлбар хийе гэж байна. Ажлын хэсгийн ахлагч, Эрдэнэбат гишүүнээр нэмэлт тайлбар хэлье.

С.Эрдэнэбат: Би, манай Үйлдвэрчний эвлэлээс ч гэсэн санал ирсэн, өмнө нь ч зөндөө яригдаж байсан. Ер нь Засгийн газрын саналыг ч дэмжихгүй байгаа юм шулуухан хэлэхэд. Энэ чинь 2, 3, 400 тэрбумын эффекттэй, цаашаа илүү нэмэгдэх, тэгээд яг ний нуугүй хэлэхэд харахаар 10 сая төгрөгөөс дээш цалинтай цөөхөн хэдэн компани л байгаа байхгүй юу. Цөөхөн хэдэн компани, Оюутолгойн өгөөжийг нэмэгдүүлэе гээд байдаг, Оюутолгойн тэр 100 сая төгрөгийн цалинтай хүмүүс нийгмийн даатгалын санд мөнгө өгөг л дөө, 50 сая төгрөгийн цалинтай хүмүүс өгөг л дөө. Тэгээд сая болохоор төрийн бус байгууллагууд гээд нэг хэдхэн ядарсан хүмүүсийг хэрэггүй, хавтгайруулна гээд хаячхангуутаа, бүр эсрэгээрээ энэ том компаниудын, алт зэсийн компаниудын лобби ч яваад байгаа юм шиг. Би энэ тал дээр цаг нь болоогүй. Тэгээд манай нийгмийн даатгал маань ийм хууль оруулж ирсэн мөнгөтэй байгаад байгаа юм шиг би харагдаад байгаа юм. Тийм учраас Засгийн газар бараг энэ саналаа татаад авбал яасан юм. Зарчмын зөрүүтэй санал гаргаад, нэг дор ингээд маш олон хөнгөлөлтүүдийг үзүүлэхээр энэ эффектээ даах уу? Эсхүл тэр том.../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгээс энэ тодорхой зарчмын зөрүүтэй саналууд дээрээ нэгд саналаа нэгтгэж орж ирэх ёстой. Байнгын хороо, чуулган дээр ингээд ажлын хэсгийн гишүүд шал 2 өөр юм яриад байж болохгүй. 2-т ажлын хэсгийн ахлагч өөрөө төлөөлөөд олонхынхоо саналаар тайлбараа хийгээд явна. Тэгэхээр би нэмэлтээр ажлын хэсгийн гишүүдээс, ахлагч тайлбар хийж байгаа тохиолдолд нэмэлт тайлбар

авахгүй ингээд явна шүү. Ингээд Энхтүвшин гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 5 гишүүн дэмжиж, санал 23.8 хувиар дэмжигдсэнгүй.

1 дүгээр зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй гишүүдээс ирсэн сүүлийн санал. Б.Түвшин гишүүн ажлын хэсгийг нэгтгэж байгуулъя гээд өөрийнхөө өргөн барьсан 41 гишүүний хамт хуулийн төслийг өргөн бариад ажлын хэсэг дээр уг нь нэгтгээд явж байгаа. Тэгэхдээ зарчмын зөрүүтэй санал сая ингээд санал хураалтууд явагдсаны ар дээр ирүүлсэн байна. Тэгэхдээ би уншиж танилцуулъя. Нэгд, энэ 4 санал ирүүлснээс эхний 2 санал нь ажлын хэсгээс гарсан санал хураалтад 1 дүгээр зүйлтэй холбогдоод санал хураагдчихсан, хураагдаад дэмжигдчихсэн учраас энэ дээр санал хураалт явагдахгүй.

1 дүгээр зүйлийг нь би уншиж танилцуулъя. Засгийн газрын өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 2.7 дугаар зүйлийн 7.11, 7.12 дахь хэсгийг хасах гэсэн санал байгаа юм. Бид 11-ээр нь санал хураачихсан. Тэгэхээр би энэ 12-оор нь тусад нь санал хураалгая. 2-т нь болохоор 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийн "гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах" гэснийг хасах гээд 13 бас хураагдчихсан. Тэгэхээр энэ 2 дугаар заалтыг хураалгах ёсгүй, ажлын хэсгийн санал хуваагдаад дэмжигдсэн учраас энэ маань дэмжигдээгүй санал гээд ингээд ороод явна гэсэн үг. Би тэгээд ирүүлсэн 2 саналын 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсгийг хасах гэсэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс тайлбар байгаа юу? Түвшин гишүүн өөрөө байна уу? Энэ санал гаргасан гишүүд өөрсдөө зарчмын зөрүүтэй саналаа тайлбарладаг баймаар байна. Тэгээд өмнөх чухал, чухал хуулиуд, Тамхины хяналтын хууль явсан. Асар олон гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргасан, саналаа авчирч өгчхөөд явчихдаг, өөрсдөө тайлбар хийдэггүй, хамгаалдаггүй, үндэслэлээ тайлбарладаггүй, тэгээд дэмжигдээгүй болохоор асуудал яриад хэвлэл рүү хандаад ингээд яваад байдаг ийм зарчимгүй байж болохгүй шүү. Тийм болохоор энэ гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа бол өөрсдөө энэ тайлбараа хийдэг байх ёстой. Ажлын хэсгээс тайлбараа хийе.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, энэ 7.11 түрүүн дэмжигдчихсэн юм чинь 7.12 угаасаа хууль зүйн бичлэгийн хувьд өмнө нь угаасаа юу яачихсан юм чинь ингээд л аваад явахаас өөр арга байхгүй. Тэгэхгүй бол 1 дүгээрт хуулийн хувьд зөрчилтэй болно гэсэн үг. Одоо 7.12 чинь "энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.7-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно" гээд нөгөө Иргэний хуулийнх нь зохицуулалтыг яриад байна шүү дээ тийм ээ, ажлын хэсгийнхэн. Тэгэхээр бид угаасаа би Байнгын хорооны гишүүддээ хэлэх гэсэн юм.

Энд хэд хэдэн дэвшилтэт зүйлүүд орсон. Нэг хүн жишээлбэл 3, 4 гэрээтэй байж болно. Их сургуулийн багш хөдөлмөрийн гэрээ их сургуультайгаа хийчихсэн байгаад хажуугаар нь ажил гүйцэтгэх гэрээ хийх юм бол хөдөлмөрийн гэрээтэй юм чинь бусад ажил гүйцэтгэх иргэний гэрээнээс нь НДШ авахгүй. 2 дугаарт, хэд хэдэн гэрээтэй байх юм бол өөрөө түүнээсээ өөр хөдөлмөрийн гэрээ байхгүй, хэд хэдэн гэрээтэй байх юм бол өөрөө түүнээсээ сонгоод хамгийн таатай нөхцөлөөрөө

шимтгэлээ төлж болно. Залуу хүн миний бодлоор бага төлье гэж бодох байх. Тэтгэврийн насанд ойртсон хүмүүс арай өндөр төлж тэтгэврээ тогтоолгоё гэж бодох байх. Дээрээс нь нэмээд шимтгэл төлж байгаа хувь хэмжээг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 нугалснаас ихгүй гээд хязгаарлаад өгчихсөн. Нөгөө талдаа энэ чинь иргэний гэрээний бүтэн дүнгээр нь авдаггүй байхгүй юу одоо ч тийм. Жишээлбэл 400 саяын барилгын ажил хийлээ гэхэд тэрүүн дээр чинь 40 сая нь хөдөлмөрийн хөлс. Ингээд барилгын материал, тээвэр гэж байх юм бол цалин хөлс гэж хэдээр нь бичсэн байна, түүнээс нь одоогийн хуулиар ч гэсэн угаасаа тэгж авч байгаа юм.

Гэхдээ үүнийг нь өндөр байна гэж үзэж байгаа бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 нугалснаас ихгүй гэхээр одоо 2 сая 100 орчмоос ихгүйгээр НДШ-ийг нь тэтгэврийн шимтгэлийг нь авна гэсэн үг. Ийм гэрээгээр ажиллаж байгаа 40 гаруй мянган, 47 орчим мянган хүмүүс байгаа. Тэгэхээр нөгөө талдаа, ялангуяа барилга, бригадын чиглэлээр ажилладаг, үйлдвэрлэлийн осолд нэрвэгдэх өндөр магадлалтай ийм хүмүүсийн нийгмийн баталгааг бид бууруулж болохгүй гэж үзэж оруулж ирсэн. Тэгэхээр түрүүн 7.11 дэмжигдсэн юм чинь 7.12-ыг манай Тамгын газрынхан харж байгаа байх. Хууль зүйн хувьд энэ ингээд угаасаа боломжгүй шүү дээ, тийм биз дээ.

П.Ганзориг: Би Тамгын газрынхнаас тайлбар авлаа. Тэгэхээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гаргахдаа зөвхөн 7.11, 7.13-аар санал хураалгаад дэмжигдсэн. Тийм болохоор Түвшин гишүүний гаргасан эхний 2 саналын 7.11, 7.13 дахь саналууд дэмжигдээгүйд тооцогдоод явна. Харин 7.12-ыг хөндөөгүй учраас заавал санал хураах ёстой юм байна, тэгэхгүй бол энэ нь сул үлдчих гээд байна. Тийм болохоор энэ дээр гишүүд саналаа өгөх нь зөв байх. Зүгээр 7.12 тусдаа хураагдах учраас энэ дээр ажлын хэсгийн ахлагч тайлбар өгч болно нэмэлт, дэмжигдчихвэл ямар зөрчил үүсэх юм, дэмжигдэхгүй бол яах юм гэдэг дээр. Үгүй бол одоо гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Байна уу, 2 номер тайлбарлая, тодорхой тайлбарлана шүү.

Б.Батжаргал: Түвшин нарын гишүүний энэ заалтыг тодруулахад, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нэг ажилтан өөр хөлсөөр ажиллах гэрээ юм уу, ажил гүйцэтгэх гэрээгээр ажил хөдөлмөр хийвэл давхар нийгмийн даатгал төлүүлэхгүй гэсэн заалт байгаа. Жишээлбэл, их, дээд сургуулийн багш нар янз бүрийн төсөл дээр ажилладаг. Тэгэхээр давхар НДШ аваад байгаа юм. Тэгэхээр их, дээд сургууль дээрээ цалингаа аваад, нийгмийн даатгалаа төлөөд явж байгаа тохиолдолд давхар тэр гэрээ байгуулсан нь ажил гүйцэтгэх гэрээ юм уу, хөлсөөр ажиллах гэрээ юм уу, тэр гэрээнээс нь НДШ-ийг давхардуулан авахгүй гэсэн энэ заалтыг энэ 7.12 дээр тусгасан байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Түвшин гишүүний гаргасан саналын томъёоллоор Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 2.7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 6 гишүүн дэмжиж, санал 28.6 хувиар дэмжигдсэнгүй. Зулпхар гишүүн дэмжээгүй юм байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал хураалт явагдаж дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсгээс санал байхгүй байгаа,

гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргах юм байна уу? Алга байна. Санал, 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Эхний хууль явж байна ерөнхий хууль. Ерөнхий хууль 10 заалттай 10 заалт тус бүрээр асуулт, зарчмын зөрүүтэй санал явна. Тэгээд дагах хуулиуд руу орно. Ерөнхий хуулийнхаа дөнгөж 3 дугаар зүйл дээр явж байна. Алга байна. Энэ дээр ажлын хэсгийн санал байгаа. Тийм, ажлын хэсгийн санал байгаа.

Ажлын хэсгээс Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 1 болон 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66,7 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбоотой 2 дахь санал. Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “биечлэн” гэсний дараа “, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн бол асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг мөн УИХ-ын гишүүн О.Саранчулуун. Гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71,4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 4 дээр ажлын хэсгийн санал байгаа. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя. Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “0.3, 1.0, 1.5” гэснийг, би харгалзуулж уншиж байгаа, “0.3, 1.2, 2.2” гэж, “10.4, 11.1, 11.6” гэснийг “10.4, 11.3, 12.3” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, санал 71,4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 5 дугаар зүйл дээр ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирсэн. Түвшин гишүүний 3 дахь зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Энэ 3 дахь санал нь зүйл, заалтууд, нөгөө хуулийн зүйл, заалтууд 4, 7 гээд олон зүйл, заалтыг хольчихсон. Яг энэ санал хураалт дундуур ирж байгаа учраас Их Хурлын Тамгын газрын ажилтнууд ажиллах үнэхээр цаг, бололцоо алга. Тэгэхдээ энд нь бид салгаад ингээд уншаад танилцуулъя. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь хэсгийн "гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах" гэснийг хасах гэсэн ийм 3 дахь санал байна. Энэ дээр ажлын хэсэг тайлбар хийх үү? Ажлын хэсгийн 2 номер хариулъя.

Б.Батжаргал: НДЕГ Батжаргал, асуултад хариулъя. Энэ хөлсөөр ажиллах гэрээтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төсөл болон ажлын хэсэг ярилцаад 1 хүртэлх гэрээгээ өөрөө сонгож, нийгмийн даатгалаа төлөх сонголтыг нь өгчихсөн байгаа. Тэгэхээр жишээлбэл 3 гэрээтэй ажил хийж байна гэж үзэх юм бол тухайн ажилтан нь өөрийн аль таатай нөхцөлтэй нэг гэрээгээ сонгоод, энэ гэрээнийхээ дүн дотор байгаа цалин хөлснөөс НДШ төлөх зохицуулалтыг нь оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ заалт давхар байна гэж үзэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: 4 номер дээр нэмэлтээр хариулъя.

Л.Мөнхзул: Үндсэндээ Батжаргал дарга тайлбарыг хэлсэн. Нөгөө талаас хөлсөөр ажиллах гэрээнээс НДШ авахаа больсон тохиолдолд хөдөлмөрийн гэрээнээс хөлсөөр ажиллах гэрээ рүү шилжих учраас даатгуулагчийн нийгмийн баталгаа алдагдах маш их эрсдэлтэй. Тийм учраас хөдөлмөрийн гэрээтэй бол хөдөлмөрийн гэрээнээс л авна, бусад төрлийн гэрээнээс давхардуулан авахгүй гэдэг заалтаар Түвшин гишүүний үндсэн санал өмнө нь хураагдаад агуулгын хувьд дэмжигдчихсэн учраас энэ заалт дордуулсан заалт болох гээд байна даатгуулагчид талдаа.

П.Ганзориг: Санал хураалт явуулъя. Тэгэхдээ би энэ томъёоллыг нь дахиад засъя. Энэ алдаатай ирчихсэн юм байна гишүүн ирүүлэхдээ. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн, энэ 5 дугаар зүйлийн санал хураалт явагдаж байгаа. Тэгэхээр энэ 5 дугаар зүйлтэй холбогдуулан "гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах" гэснийг хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 2 гишүүн дэмжиж, санал 9.5 хувиар дэмжигдсэнгүй. Энэ 3 дахь саналыг нь 2 хувааж санал хураалгах юм байна. Задалж 2 санал хураалт явуулна гэсэн үг.

Тэгэхээр яг саяын агуулгаар буюу 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын "гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах" гэснийг хасах гэсэн саналын томъёолол байна, агуулга яг адилхан гэсэн үг. Санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 2 гишүүн дэмжиж, санал 9.5 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 76.2 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүний саналыг уншиж танилцуулъя. УИХ-ын гишүүн Түвшингээс ирсэн 4 дэх санал. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.10 дахь заалт, мөн зүйлийн 7.10 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгох. Санал гаргасан УИХ-ын гишүүн Б.Түвшин. Ажлын хэсгээс тайлбар байгаа уу? Байхгүй байна. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 3 гишүүн дэмжиж, санал 14.3 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсгийн “шимтгэл төлөлтийн” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “тухайн гэрээ бүрт” гэснийг, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт болон 7, 10 дугаар зүйлийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томьёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс 1 дүгээр зүйл дээр байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай, ажлын хэсгийн саналыг танилцуулъя. Нэгтгэсэн төсөлд 2 дугаар зүйл шинээр нэмэх.

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 3 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журам, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 61.9 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 23 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.8.“суурь тэтгэвэр” гэж авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тус тус авч байгаа ахмад настанд улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Энэ дээр гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гарсан юм. 1 дүгээр зүйлтэй холбоотой. Гишүүдийн саналыг хураалгая. УИХ-ын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. "Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг хассугай" гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан байна. Санал гаргасан гишүүдээс тайлбар хийх үү? С.Эрдэнэбат гишүүн тайлбар хийе.

С.Эрдэнэбат: Энэ нийгмийн даатгалын хуулиар бүх салбар хуулиудын насны асуудлыг энэ хуулиараа хэрвээ шийдье гэж байгаа бол өөр цэрэг, прокурор, шүүх гээд маш олон хуулиуд дээр ингээд салбар орчихсон ийм байгаад байгаа юм. Тийм

учраас тэр зүйлүүд чинь хоорондоо зөрчилдөөд байгаа учраас зөвхөн энэ хуулиар гэдэг нь яг нийцэж байна уу, үгүй байна уу гэдэг талаар гаргасан санал юм.

П.Ганзориг: Ажлын хэсгээс тайлбар байгаа уу? 4 дээр тайлбарлая. 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: С.Эрдэнэбат гишүүний хэлж байгаа тодорхой үнэн. Яагаад гэхээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль дээр тэтгэврийн насны зохицуулалт байгаа. Гэхдээ энэ заалт дээр нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн насыг зөвхөн энэ хуулиар гэж байгаа учраас тухайн хуультай зөрчилдөхгүй. Тийм учраас энэ заалтыг аваад явах нь ирээдүйд тэтгэврийн насыг зөвхөн энэ хуулиар зохицуулах нь хууль хоорондын хэрэглээний хувьд нэлээд дэвшилтэт зүйл гарч ирэх юм.

П.Ганзориг: Гишүүдийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 8 гишүүн дэмжиж, санал 38.1 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг уншъя. Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.7 дахь заалтыг хассугай. 2 тусдаа унших юм байна. Гишүүдээс тайлбар байгаа юу, ажлын хэсгээс тайлбар байна уу? Алга байна. Санал хураалт. Байгаа юм уу? 2 номерын микрофон.

Б.Батжаргал: Эрдэнэбат нарын гишүүдийн асуултад хариулъя. Одоо баталгаат тэтгэвэр гэдэг ойлголт цоо шинээр орж ирж байгаа. Энэ маш том нийгмийн хамгааллын том арга хэмжээ болно. Энэ мөнгөн дүн их наядаар яригдаж байгаа. Тэгэхээр энэ баталгаат тэтгэврийг авах нас 55, 60 гэсэн нас руу очиж байна, энэ хүн насанд хүрээд авна. Тэгэхээр аль болох энэ насанд хүрсний хүрэх насыг л бид тогтоох хэрэгтэй шаардлагатай болоод байна. Тэгэхээр одоо тэтгэвэр авч байгаа олон хүүхэдтэй эхээр тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тоо асуудалд нэг олон асуудал нь юу вэ гэхээр цөөн жилтэй учраас нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэвэр нь бага байгаа тухай гомдол өргөдлийг маш их ирүүлдэг. Яагаад цөөн жил байгаа шалтгаан нь 50 насандаа эрт гарчихдаг учраас тэтгэврийг боддог дундаж аргачлал нь бага болоод бага тэтгэвэртэй болоод байгаа. Өнөөдрийн байдлаар 118 мянган эхчүүд олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тэтгэвэрт гараад тэтгэврээ авч байна. Ийм учраас энэ олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэврийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах зорилгоор энэ насыг, тэгэхдээ огцом биш, жилд 3 сараар буюу энэ хууль хэрэгжиж эхэлсэн тохиолдолд 50 нас 3 сартайдаа тэтгэвэртээ гарна гэдэг ийм агуулгаар хуулийн төсөл бичигдсэн байгаа. Тэгэхээр энэ урт хугацаандаа баталгаат тэтгэврээ авах боломжийг нь 1 дүгээрт бүрдүүлнэ. 2 дугаарт нийгмийн даатгалын сангаас авах тэтгэврийг нэлээн боломжийн дүнгээр авах үндсэн нөхцөлийг бүрдүүлэх юм. Баярлалаа.

П.Ганзориг: Санал гаргасан Мөнхтуяа гишүүн тайлбар хийе.

Ц.Мөнхтуяа: Энэ 4 хүүхэд төрүүлсэн эхчүүд насаа ингээд нэмэхийг хүсэхгүй байгаа. Тийм болохоор энэ дээр сайн бодож үзэх хэрэгтэй байх шүү. Санал аваагүй ингээд шууд оруулж ирж болохгүй гэж байна.

П.Ганзориг: Гишүүдийн гаргасан саналын томьёоллоор, Мөнхтуяа гишүүн болсон уу?

Ц.Мөнхтуяа: Баярлалаа. Хүсвэл байгаа юм байна тийм үү, тэтгэврийн нас. Тийм байна хүсвэл гэж байгаа юм байна.

П.Ганзориг: Саяын Эрдэнэбат, Мөнхтуяа гишүүн нарын гаргасан саналын томьёолол хуульдаа агуулгын хувьд орсон байгаа юм байна. Гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 4 гишүүн дэмжиж, санал 19 хувиар дэмжигдсэнгүй.

Энхтүвшин гишүүний гаргасан саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг 9.1.3-д “нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авч байх.” гэснийг хасах. Энхтүвшин гишүүн тайлбар байгаа юу? Энхтүвшин гишүүн тайлбарлая.

Д.Энхтүвшин: Энэ хууль дээр өндөр насны тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагч нас барсан тохиолдол гээд 2 нөхцөл байгаа юм. Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн бол 20 ба түүнээс дээш хамт амьдарсан бол гээд энэ заалт дээр дахиад нэг шинэ нөхцөл нэмж байна. Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх гэдэг. Тэгэхээр энэ нь өөрөө энэ Гэр бүлийн тухай хуулиар хамт бүртгүүлчихсэн 20-оос дээш амьдарчихсан мөртөө энэ баталгаат тэтгэвэр авагч мөн бишээс хамаараад энэ тэтгэврийг нь энэ шилжилт хөдөлгөөний 9.1 дэх заалтыг хязгаарлаж байгаа учраас энийг нь энэ заалтыг хасъя гэсэн ийм санал байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс тайлбар байгаа юу? 2 номер тайлбарлая.

Б.Батжаргал: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. НДЕГ-ын дарга Б.Батжаргал. Энэ зохицуулалт өмнө нь 2023 оны Их Хурлаас баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуультай ижил төстэй заалтаар мөрдөгдөж орж ирж байгаа. Тэр үед хоёулаа өндөр насны тэтгэвэр авч байгаа тохиолдолд аль нэг нь бурхан болсон үед ар гэрт үлдсэн эхнэр юм уу, нөхөр нь 20 хувийн тэтгэврийг нь авч үлдэх ийм зохицуулалт 2024, 25, 26 онд хэрэгжээд ингээд явж байгаа учраас энэ зохицуулалттай адилхан зохицуулалтаар нь оруулж ирж оруулж байгаа. Тэгэхдээ илүү өргөжүүлээд хуучин одоо мөрдөж байгаа нь хоёулаа өндөр нас байгаад нэг нь групп авдаг бол болохгүй байгаа бол одоо баталгаат тэтгэвэр гээд ерөнхийдөө эрхийг нь нээгээд өгчхөж байгаа юм. Энэ нэлээн боломжтой тийм хувилбар, баярлалаа.

П.Ганзориг: Энхтүвшин гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энхтүвшин гишүүн өөрөө байхгүй билүү ирцэд. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 4 гишүүн дэмжиж, санал 19 хувиар дэмжигдсэнгүй. Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Мөнхтуяа, Эрдэнэбат нарын гишүүдээс гаргасан төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг хассугай гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байна. Гишүүдээс тайлбар байгаа юу? Алга байна. Ажлын хэсгээс? Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг тус тус асуугаарай. Саяын санал хураагдсан санал байна шүү, энэ солиод ирчхэж. Одоо би яг хамааралтай заалтыг нь уншаадахъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар зүйлийн

7.8 дахь заалтыг бүхэлд нь хассугай гэсэн санал байна. Санал гаргасан Мөнхтуяа, Эрдэнэбат нарын гишүүд. Гишүүдээс санал байгаа юу тайлбар, ажлын хэсгээс тайлбар байгаа юу? 7.8 дахь заалтыг бүхэлд нь хасах гэж байна шүү дээ. Гаргасан саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё. Эрдэнэбат гишүүн тайлбар.

С.Эрдэнэбат: Энэ юу юм тэтгэвэрт арай эрт гарахаар нь хасах коэффициент бодоод байгаа юм. Тийм тийм учраас тэрийг заавал хасах хэрэг байна уу гэдэг байдлаар санал оруулсан юм.

П.Ганзориг: Мөнхтуяа гишүүн, Эрдэнэбат гишүүн нарын гаргасан саналын томъёоллоор санал. Хураалт санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 5 гишүүн дэмжиж, санал 23,8 хувиар дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гарсан саналууд. Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэгт дурдагдсан “2027” гэснийг “2027, 2028” гэж, “2028” гэснийг “2029” гэж, “2029” гэснийг “2030” гэж, “2030” гэснийг “2031” гэж, “2031” гэснийг “2032” гэж “2032” гэснийг “2033” гэж тус тус харгалзуулан өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 61,9 хувиар дэмжигдлээ.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.8 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 13 гишүүн дэмжиж, санал 61,9 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйл дээр Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Суурь тэтгэврийг доор дурдсан насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгоно:

3.4.1.өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч;

3.4.2.энэ хуулийн 5.1.2-5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй 60 насанд хүрсэн, эмэгтэй 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч, мөн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсан тэтгэвэр авагч.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 12 гишүүн дэмжиж, санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийн насыг нэмье гэдэг ийм санал байсан ЗГ-ын төсөл дээр. Энийг миний хувьд энэний өмнөх 23 оны хуулиар ч гэсэн хүнд нөхцөлд ажиллаж байгаа олон хүн байгаа. Энэ хүмүүсийн насыг нөхцөлийг нь сайжруулахгүйгээр шууд насыг нь нэмээд явна гэдэг нь зарчмын хувьд логикийн хувьд мөн эрсдэлийн хувьд таарахгүй юм гэдэг энэ саналыг гаргасан. Яг энэ санал хэлэлцэх явцад өчигдөр 5 дахиад авхуулаад ЗГ-тай манай үйлдвэрчний эвлэлийнхэн уулзсан байна лээ.

Нөгөө талаасаа бид ер нь энэ асуудлыг Давхар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуультайгаа мөн энэ нөхцөлийг нь сайжруулах сонирхлыг ажил олгогч нарт тавихгүй бол нөхцөл хүнд нөхцөлд жишээлбэл уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр гээд шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоогдсон ийм насны асуудлыг шууд автоматаар сангийн хүндрэлтэй холбоотойгоор нэмэх гэдэг нь буруу юм гэдэг ийм санал шаардлагыг ЗГ ерөнхийдөө хүлээж аваад буцаагаад татъя гэдэг ийм зарчмын байр суурь яриад ажлын хэсэг дээр бид санал хураагаад, хөдөлмөрийн хүнд нөхцөлийн нас нэмэх асуудлыг энэ удаадаа орхиё гэдэг байдлаар нэгдсэн зөвшилцөлд ЗГ, үйлдвэрчний эвлэл, ажлын хэсэг хүрсэн учраас миний энэ саналыг ажлын хэсгийн саналтай нэгтгэн хураалгаж өгөхийг хүсэж байна.

П.Ганзориг: Ажлын хэсгээс тайлбар хийе. Ажлын хэсгийн ахлагч.

Х.Булгантуяа: Насыг нэмээд тайлбарлаадхаарай. Хүндийг бид ингэсэн юм хэн Эрдэнэбат гишүүний саналтай санал нэгтгээд нийлээд хүнд тэтгэвэрт хүнд нөхцөлөөс тэтгэвэрт гарах насыг бид нэмээгүй. ЗГ-аас нэмж оруулж ирсэн байсныг буцаж бууруулаад өмнөх хэмжээнд нь аваачъя гэдгээр ажлын хэсэг дээр санал хураалгаад дэмжигдсэн байж байгаа. МҮЭХ ялангуяа үүн дээр нэлээн хатуу байр суурь илэрхийлсэн. Ингээд хүнд нөхцөлийг бууруулах хөтөлбөр гаргая, ХАБ-ын тухай хуулиа сайжруулъя, үүний хэрэгжилтийг нэмэгдүүлъя гэдэг ийм саналуудыг Тамир дарга үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Тамир дарга гаргасан. Тэгээд ажлын хэсэг дээр энэ дэмжигдсэн юм Байнгын хорооны дарга.

П.Ганзориг: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? Хэдэн номер вэ? 8 дээр нэмэлт хариулъя.

Э.Тамир: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхлээр хөдөлмөрийн хүнд хортой хэвийн бус нөхцөлийг ер нь Монгол Улс байхгүй болгох тодорхой ажил мэргэжлүүдийг хэвийн нөхцөл рүү шилжүүлэхтэй холбоотой асуудал дээр МҮЭХ дэмждэг. Гэлээ гэхдээ яг одоогоор яг хөдөлмөрийн нөхцөлийнхөө асуудлыг бид хэвийн нөхцөл рүү шилжүүлж чадаагүй байгаа энэ нөхцөлд нэгэнтээ эрүүл мэнд аюулгүй байдлаараа тодорхой эрсдэлтэй ажлын байрыг хийж байгаа улсуудад нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийн тодорхой тусгай зохицуулалтууд хэрэгжээд явдаг.

Тэгэхлээр ер нь цаашдаа МҮЭХ-ноос болоод Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа хамтраад энэ хүнд нөхцөл дээр ажиллаж байгаа ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийг хэвийн болгохтой холбоотой нэгдсэн тийм бодлого стратеги боловсруулж хэрэгжүүлъя. Энэнийхээ дараа тодорхой хэмжээнд

шууд сайжралт гарсныхаа дараагаар яг энэ хүнд нөхцөл дээр байгаа тусгай зохицуулалтуудын асуудлыг эргэн авч үзэх боломжтой юм гэдэг санал байр сууриудыг илэрхийлж байгаа. Тэгээд МҮЭХ-ны гишүүдийн хувьд ч гэсэндээ яг энэ хүнд нөхцөлтэй холбоотой.../минут дуусав/

П.Ганзориг: 4 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн, юуг хамтатгаж хураая гэж, энэ дээр үү? Ажлын хэсгийн гишүүн юм чинь таны нэр орсон байгаа угаасаа. Ижил саналтай гээд. Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, санал 71,4 хувиар дэмжигдлээ.

Гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя. Мөнхтуяа, Эрдэнэбат нарын гишүүдээс ирсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.7 дахь заалтыг хассугай гэсэн саналын томьёолол. Гишүүдээс нэмэлт тайлбар байгаа уу? Ажлын хэсгээс тайлбар байна уу? Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.7 дахь заалтыг, хуулийн төслийн 2 дахь хэсгийн 4 дэх зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж энийг хассугай гэсэн юм байна. Түрүүчийн ажлын хэсгийн гаргадаг, санал хураалгадаг 5 дахь зүйлийн санал 5.1.5, 5.1.3 гэхихээр олон хүүхэдтэй ээжийн насны асуудал байгаа юм, тэгээд ажлын хэсэг энэ дээр өөрөө харж байгаад, би энэ заалтыг нь маш тодорхой уншиж байна шүү дээ. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дүгээр зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэсэн байгаа, энийг хассугай гэсэн санал байхгүй юу. Энэ дээр ажлын хэсэг тайлбар, 2 номерын микрофон.

Б.Батжаргал: НДЕГ Батжаргал. Энэ заалтын хувьд олон хүүхдээр тэтгэвэрт гарч байгаа, 50 насандаа гарч байгаа эхчүүдийн насны асуудал байгаа. Түрүүн тайлбараа хэлсэн. 1 дүгээрт энд одоо баталгаат тэтгэврийн асуудал орж ирж байгаа тэтгэврийн тогтолцооны хүрээнд. Энэ ямар насанд хүрсэн хүмүүс авах вэ гэхээр 55 насанд хүрсэн эмэгтэй, 60 насанд хүрсэн эрэгтэй хүн авахаар ийм зохицуулалт явж байгаа. Тэгэхээр энэ эрт тэтгэвэрт гарах тусам ажилласан жил нь бага байдаг учраас энэ эрт тэтгэвэрт гарсан хүмүүсийн олонх нь тэтгэврийн доод хэмжээ рүү унаж байна. Яагаад вэ гэхээр 20 жил ажиллаад гарахаар дундаж цалингийн 45 хувиас дээшээ өсөхгүй байгаа, хэрвээ 5 жилээр илүү буюу 55 насандаа гарвал 52.5 гэх мэтчилэн ингэж өсөж явдаг. Тэгэхээр энэ одоо тэтгэвэрт гарсан, олон хүүхдээр тэтгэвэртээ гарсан хүмүүсийн тоо 118 мянган эхчүүд байгаа, эмэгтэй тэтгэвэр авагчид. Манайд ирж байгаа гомдлын нэлээдгүй.../минут дуусав/

П.Ганзориг: Гишүүдийн гаргасан, Мөнхтуяа, Эрдэнэбат гишүүдийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 6 гишүүн дэмжиж, санал 28.6 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт болон зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасаж, дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Баатархүү гишүүн түрүүний гаргасан асуудлаараа дэгийн хуулийн тайлбарыг нь сонсчихсон, тэгээд тэрүүгээрээ саналаа хураалгахгүй татъя гэдэг тайлбараа микрофон дээр хэлье. Баатархүү гишүүний микрофоныг өгье.

Ц.Баатархүү: Нийгмийн бодлогын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэтгэврийн асуудал нийгмийн анхаарлын төвд орсон, олон ахмадууд хүлээж байгаа, тодорхой хэмжээний шинэчлэлийг ингэж оруулж ирж байгаа гэж харж байна. Нэмэлт, өөрчлөлт учраас томоохон реформын шинжтэй, тогтолцооны шинжтэй найруулга, шинэчилсэн найруулга, бүрэн найруулгыг хийх боломжгүй байна гэдгийг албан ёсоор протоколд хэлье.

Өнөөдөр нийт тэтгэврийн насны хүмүүсийн 70 орчим хувь нь тэтгэврийн зээлтэй байна. Тэтгэврийг жил болгон инфляцтай дүйцүүлж нэмнэ гэдэг хуулийн заалт өөрөө логикийн хувьд алдаатай байсан. Инфляц гэдэг мөнгө үнэгүйдэхээр тэтгэвэр нэмнэ гэдэг тэтгэвэр нэмж байгаа гэсэн үг биш. Тэгэхээр цаашдаа Засгийн газар тэтгэврийг нэмэхдээ өнгөрсөн жилийн инфляцтай уялдуулахаас гадна тухайн жилийн хөдөлмөрийн орлогын өсөлт буюу дундаж цалингийн өсөлттэй уялдуулж тэтгэврийн хэмжээг нэмэхгүй бол одоо ажиллаж байгаа хүмүүсийн хөдөлмөрийн орлого, бодит цалин нэмэгдэхээр тэтгэвэр зөвхөн инфляцтайгаа уялдаад нэмэгддэггүй яг ингээд байрандаа байгаа учраас хүмүүс тэтгэврийн зээл авч байна.

Тэгэхээр ахмадуудаа тэтгэврийн энэ зээл, зээлийн дарамт, өрийн дарамтаас сэргийлэх, тэтгэврийн урьдчилгаа гэдэг ийм заалтыг оруулж ирж байгаа. Энэ заалт маань ахмадууд сарын тэтгэврийн хэмжээтэй урьдчилгааг хүүгүй, барьцаагүй, жилд нэг удаа авах эрх олгоод, тэгээд дараагийн 12 сардаа хуваагаад тэтгэврийнхээ хэмжээнээс хуваан суутгуулж болох ийм заалт байсан. Энгийнээр хэлбэл 800 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн бол жилдээ нэг удаа хүсвэл 800000-ын хүүгүй урьдчилгаа аваад сар болгон 66 мянган төгрөгийг хасуулаад суутгуулаад явах ийм шинэчлэл байгаа. Энийг шинэчилсэн найруулгын төсөл дээр өргөн мэдүүлье гэдэг ийм саналтай байна, та бүхэндээ баярлалаа.

П.Ганзориг: Яг саяын тайлбартай ижил агуулгатай саналын томьёолол Мөнхтуяа гишүүн, Эрдэнэбат нарын гишүүд гаргасан. Тэгээд Эрдэнэбат гишүүн тайлбар хийгээд саналаа татаж байгаагаа тайлбарлая.

С.Эрдэнэбат: Ийм 2 заалт байсан юм. 1 дүгээрт, зарим салбарыг тусгайлан авч үзэхгүй гэдэг ийм асуудал байгаа. Гэхдээ энэ боловсролын салбар, тухайлбал бага ангийн багш нар, цэцэрлэгийн багш нар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нар энэ тэр гэдэг ийм юмыг оруулж ирэхгүй бол нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дааж ажиллаж байгаа багш бол хөдөлмөрийн нэлээн хүнд нөхцөл рүү орохоор ийм байгаа 1 дүгээрт. 2 дугаарт юу вэ гэхээр дуу хөгжмийн багш 55 хүрчхээд хүүхдүүдэд дуу, бүжиг заах л ийм л юм болчихоод байгаа байхгүй юу. Биеийн тамирын багш гээд зарим ийм төрлийн багш нарын хөнгөлөлттэй нөхцөлд гарахыг нь ажлын байрных нь үнэлгээ, дүгнэлтийг хийгээд салбараар нь, нийтээр нь биш юм гэж бодоход бага ангийн багш, цэцэрлэгийн багш, мөн биеийн тамир, дуу хөгжим, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг гэх мэтчилэн ийм хүмүүсийн ажлын байрных нь зураг авалтыг хийгээд, Аубакир сайдаа энэ асуудлыг ер нь нэг тийш нь гаргахгүй бол энэ нэлээн олон жил яригдаж байгаа асуудал учраас энэ асуудлыг хэдүүлээ ХАБЭА-н тухай хуулийнхаа дагуулаад энэ зарим ингээд олон жил хүлээлттэй байгаад байгаа юмыг нь үнэлгээг нь зөв хийгээд, тэгээд болж өгвөл хэдүүлээ 2028 ондоо багтаагаад энэ чуулганыхаа үеэр энэ багш хүмүүсийн мэргэжлийн хүнд, хортой нөхцөл, насыг нь хөнгөлөх гэдэг асуудлыг нэг оруулж ирье. Тийм учраас Засгийн газар ХАБЭА-н тухай хуулийнхаа дагуу оруулж ирвэл энэ бүрэн бололцоотой. Тэгээд энэ заалтыг маань сая чуулганы дэгийн тухай хуулиар

Засгийн газраас хөндөөгүй учраас энэ удаад санал хураалгах боломжгүй байна. Гэхдээ энийг протоколд тэмдэглүүлээд та бүгд маань энэ саяын зарчмын оруулсан энэ саналыг дараагийн ээлжид ажил нь хэвээрээ цаашаа үргэлжлээд хийгдээд, энэ багш нар боловсролынхоо асуудал дээр тусгайлан ажлын хэсэг гаргаад энэ үнэлэлт дүгнэлт өгөх ийм асуудал байна.

Дараагийнх нь болохоор манай боловсролын салбарынхан яриад байдаг юм, хэрвээ насыг нь буулгахгүй ийм байгаа нөхцөлд энийг 45 хувиар, 40-өөр тогтоож 45 хувиар тогтоож байгааг нь жоохон нэмье гэдэг ийм зүйл гараад байдаг юм. Тийм учраас энийг ч гэсэн мөн ялгаа байхгүй та бүгд энэ дэгийн хуулиар хөндөгдөөгүй заалт учраас санал хураах боломжгүй ч гэсэн энэ нөхцөлүүдтэй нь уялдуулаад боддог аргачлалуудыг нь, цэргүүд магадгүй хүнд нөхцөлд ажиллаж байгаа бол, бага ангийн хүүхдэд 50 хүүхэдтэй, 60 хүүхэдтэй ангид ажиллаж байгаа багш нар байна, зарим нь 10 хүүхэдтэй ажиллаж байгаа багш байна. Тэгэнгүүт хоёулаа багшийн хөдөлмөр эрхлэлт хүнд, хөнгөн гэж хэлэхэд их зөрөөтэй асуудал байгаа учраас нөхцөлийг нь харгалзаж байгаад энэ 45-ыг нь тэтгэвэрт гаргахад нь урамшуулах тогтолцоог энэ нэмэлт тэтгэврийн тэр асуудлаар урамшуулах энэ асуудлыг зайлшгүй бодлогын хувьд оруулах хэрэгтэй байна гэдгийг саналаа уншаад өгчихье.

П.Ганзориг: Нэгтгэсэн төслийн “баталгаат тэтгэвэр” гэснийг “суурь тэтгэвэр” болгон өөрчилсөнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгасан “баталгаат тэтгэвэр”-тэй холбоотой зүйл, хэсэг, заалтуудыг уялдуулан өөрчлөх, тус тус найруулах гээд ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Дараагийн хууль. Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Гишүүд алга байна. Ажлын хэсгийн саналгүй. Гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирсэн. Одонтуяа гишүүнээс ирсэн зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах гэсэн ийм саналын томъёоллоор зарчмын зөрүүтэй санал ирсэн.

Би энэ Прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирсэн, энэ Байнгын хороодод ирсэн товчхон бичгийнх нь агуулгыг тайлбарлаж уншихъя. УЕПГ болон ШЕЗ-өөс тус тус ХЗБХ болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд, дээр нь нэмээд УИХ-ын даргад энэ прокурор болон шүүгчийн тэтгэвэрт

гарах насыг хойшлуулж байгаа, өмнөх заалтыг хүчингүй болгож байгаатай холбогдуулан нэгд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хууль боловсруулахдаа хууль боловсруулах шаардлагын дагуу эрх нь хөндөгдөж байгаа Прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал аваагүй гэдэг ийм асуудлыг нэгд дурдсан.

2-т, прокурор, шүүгчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор оруулсан гол энэ заалтуудаа ингээд хүчингүй болгож байна гэсэн ийм асуудлуудыг ирүүлсэн. Тэгээд энэ асуудлыг би ажлын хэсэгт цохоод явуулчихсан байгаа. Тэгээд Засгийн газраас өргөн барьсан учраас энийг Засгийн газраас тайлбараа хийгээд, тодорхой ажлын хэсэг дээр энэ асуудлуудаа цааш нь тайлбар өгөөд явах нь зүйтэй байх. Тайлбар ажлын хэсгээс Аубакир сайд.

Т.Аубакир: Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийг хүчингүй болгосонд тооцсугай гэсэн, мөн энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн хуулиа 1 дүгээрт татаж авъя. Санаачлагчийн хувьд хэлэлцүүлгийн аль ч шатад эргэж татаж авах эрхтэй энэ хүрээнд.

2 дугаарт, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг хүчингүй болгонд тооцсугай гэсэн заалтуудаа эргүүлэн татъя.

П.Ганзориг: Одонтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 9 гишүүн дэмжиж, санал 42.9 хувиар дэмжигдсэнгүй. Засгийн газраас өргөн барихдаа энэ хуулийн эрх нь хөндөгдөж байгаа талаас санал авах энэ процессын алдаа гарсан. Тийм болохоор өөрсдөө энэ хэлэлцүүлгийн явцад бичгээр саналаа өгөөд "татъя" гэдэг санал, тайлбараа хэлж байгаа юм байна. Тэгэхээр энэ чуулганы хуралдааны үеэр Засгийн газраас Их Хурлын даргад энэ бичгээ хүсэлтээр өгөөд энэ асуудлаа тэр зохицуулалтаараа шийдээд явах нь зүйтэй байх.

Ингээд дараагийн хуулийн санал хураалт. Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Одонтуяа гишүүн дахиад яг ижил агуулгатай Шүүхийн хууль дээр санал ирүүлснийг уншиж танилцуулъя. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан Одонтуяа. Би түрүүн бичгийнх нь тайлбарыг хэлсэн, агуулга нь яг адилхан гэсэн үг. Хууль санаачлагчид буцаах. Одонтуяа гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 9 гишүүн дэмжиж, санал 42.9 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн хуулийн санал хураалт. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс саналтай. Гишүүдийн санал байвал бэлдэж

байгаарай. Дагаж мөрдөх журмын тухай хууль биз дээ? Энэ дээр чинь дагаж мөрдөх байхгүй шүү дээ, одоо цөөхөн үлдэж байгаа.

Ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 10 гишүүн дэмжиж, болохгүй шүү дээ энэ чинь. Тэгвэл Эрдэнэбат гишүүн горимын санал гаргая.

С.Эрдэнэбат: Сая төхөөрөмж гацчихсан учраас саяын саналыг хүчингүй болгож, дахиж хурааж өгнө үү.

П.Ганзориг: Саяын саналыг хүчингүй болгох саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал хүчингүйд тооцогдлоо. Түрүүчийн хэлсэн саналын томьёоллоор 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төсөлд 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийг” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал. Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал. Нэгтгэсэн төслийн 3, 4 дүгээр зүйлийг хасаж, дугаарлалтыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал. Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр олгогдсон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр (C_T)-ийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 71.4 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Наадах чинь 1 юм уу? 1 дүгээр зүйл дээр гишүүд зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна. Та нар яг уншиж дуусаад, 2 руу орохоосоо өмнө амжуулж өгөөрэй. Эрдэнэбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Төслийн 14.1.6 дахь заалтын “засах” гэсний дараа “гэрээр асрах, сувилах болон хувилбарт тусламж” гэж нэмэх. Санал гаргасан Эрдэнэбат гишүүн тайлбар байгаа уу? Эрдэнэбат гишүүн тайлбарлая.

С.Эрдэнэбат: Энэ үйлдвэрлэлийн ослын даатгалын сангаас ганцхан тэтгэмж болон ортопедийн хэрэгсэл гэдэг хоёрхон юм байгаад байдаг, нэлээн их мөнгө нь хуримтлагдсан, зарцуулж болдоггүй. Тийм учраас ядаж энэ үйлдвэрлэлийн осол, хурц мэргэжлээс шалтгаалах өвчлөлтэй хүмүүст асрах, сувилах гэдэг энэ үйлчилгээг одоогоос бид энэ хуульдаа оруулаад явах нь зөв юм. Тэгэхээр энэ заалт яах вэ, ямар ч байсан ийм гарцыг нь нээгээд өгье, дагах нөгөө нэг ХАБЭА-н тухай

хууль дээрээ илүү тодорхой болгоод, энэ энийг нь санхүүжүүлнэ, бүр цаашлаад бодож байгаа бодол маань цаашаа дэмжигдээд явна. Манай мөн Ахмад настны тухай хууль гэдэг юм уу, бусад хуулиуд дээр асрах, сувилах, хувилбарт үйлчилгээ гээд юмнууд байгаа. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлтэй хүмүүст нэг удаа тэтгэмж өгөөд л үндсэнд нь бараг хаядаг энэ юмаа больё, санд нь мөнгө тодорхой хэмжээгээр байгаа бол ядаж осол аваарт өртсөн хүмүүст нь гэрээр асрах, сувилах, хувилбарт үйлчилгээний юмыг нь нээж өгье гэж байгаа юм. Тэгэхгүй болохоор хууль байхгүй болохоор зарцуулж болдоггүй ийм зүйл байгаад байгаа учраас ийм зарчмын саналыг оруулж байгаа юм, дэмжиж өгөхийг хүсье.

П.Ганзориг: Хөндөгдсөн заалт юм байна. Ажлын хэсгээс тайлбар байна уу? Ажлын хэсгийн ахлагч тайлбар хийе.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүний саналыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм Эрдэнэбат гишүүнээ. Тэгэхдээ би ингэж бодоод байгаа юм. ХАБЭА-н тухай хуулийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Тамир ерөнхийлөгч, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын хувьд ч гэсэндээ нэлээдгүй хэлэлцэж, үүнийг нэлээн сайн хууль өргөн барья гэж санал гаргасан. Тэгээд Засгийн газраас өргөн барьсан байгаа хуулиа буцааж татъя гэсэн. Тэгэхээр үүнтэй холбоотой зохицуулалтуудаа нэлээн сайн болгож оруулж ирэх нь зүйтэй байх гэж 1 дүгээрт би бодож байна.

2 дугаарт, ер нь би Эрүүл мэндийн сайдтай өмнө нь ярьж байхад ялангуяа энэ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүдээд урьдчилан сэргийлэх, дээрээс нь нэмээд эмчилгээ, оношилгоо, асаргаатай холбоотой зохицуулалтуудыг 2 сангаас хамтдаа үүнийг санхүүжүүлэх нь зүйтэй юм байна гэж манай Чинзориг сайд хуучин салбарын сайдаар ажиллаж байсан хүний хувьд үзэж байсан. Би энийг зүйтэй юм байна гэж бодож байгаа. Тэгэхдээ давхардуулахгүй 1 дүгээрт, 2 дугаарт сангийн зарцуулалт, тооцоолол дээр та бүхэн маань үзэж байгаад, ХАБЭА-н хуульдаа нэгдсэн байдлаар үйлдвэрчний эвлэл нэг сайн хэлэлцүүлэг хийж байгаад ажил олгогчтойгоо нийлж байгаад хийвэл зүгээр юм биш үү гэдэг зүгээр ийм саналтай байгаа юм.

П.Ганзориг: Эрдэнэбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, санал 61.9 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй тэтгэвэр авагчид 60 насанд, эмэгтэй тэтгэвэр авагчид 55 насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр (C_T)-ийг тооцон олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгийн саналтай. Нэгтгэсэн төсөлд 3 дугаар зүйлийг өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1} дэх хэсэгт заасан баталгаат тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Би юу асуух гэж байна вэ гэхээр, энэ нөгөө суурь тэтгэвэр энэ тэрийг тогтооход нөгөө хэмжээг нь Засгийн газар биш, нөгөө Үндэсний зөвлөлөөрөө ярина гэдгээр тохирсон гэсэн тийм ээ? Тэр заалтаар орж ирж байгаа юу, Аубакир сайдаа, ажлын хэсэг, Булгантуяа гишүүн?

П.Ганзориг: Гишүүдээ энэ яг зүйл, заалттай нь холбогдуулж асуумаар байна. Ерөнхий юмтай, одоо би заалт болгоноор явж байгаа шүү дээ. Гэтэл үсрээд өөр заалт руу орж ингээд асуугаад байхаар болохгүй байгаад байна. Биш, энэ 5 дугаар зүйлд огт хамаа байхгүй.

Хуулийн төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах, асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байхгүй тийм ээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байна уу? Байхгүй байна.

Хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Гишүүдийн санал, зарчмын зөрүүтэй санал байгаа. Энхтүвшин гишүүнээс гаргасан саналын зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 11.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараа өдрөөс эхлэн ажлын 55 хоногоор тооцон олгоно” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Д.Энхтүвшин. Энхтүвшин гишүүн тайлбар хийе.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн заалт нь болохоор адил хэмжээний шимтгэл төлчхөөд, ажлаас гарсан шалтгаанаасаа болоод 2 өөр төрлийн хоногоор ажилгүйдлийн тэтгэмж авах гээд байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн 16.4 дээр ажлаа сонгох эрхтэй гээд заачихсан байгаа, дээр нь 14.2 дээр үзэл бодлоор нь яаж чөлөөлөгдөхөөс нь хамаараад ингээд үзэл бодлоор нь ялгаварлаж байгаа юм шиг байгаа учраас энэ ажил олгогчийн санаачилгаар эсвэл өөрийнхөө санаачилгаар гэдгийг 2 өөр 21 хоногийн зөрөөтэйгөөр ингэж тооцсон нь бараг 30 хувь болж байна. Тэгэхээр ийм ялгаатай байсныг нэг болгож жигдэлье гэсэн санаа байгаа юм. Одоогийн хууль дээр яг адилхан байсныг хуулийн төсөл дээр ялгавартайгаар 21 хоногийн зөрөөтэйгөөр ажилгүйдлийн тэтгэмжийг олгохоор ингэж орж ирсэн байгааг нэг болгож жигдэлье гэсэн ийм санал байгаа юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч тайлбар хийе.

Х.Булгантуяа: Энэ асуудлаар МҮХАҮТ-ынхан саналаа хэлсэн. Энхтүвшин гишүүний хэлж байгаа зарим бол үндэслэлтэй. Жишээлбэл, хүн өөрөө ажлын байраа сайжруулах гэж, эсвэл ажил олгогчийн ажлын байрны нөхцөл таалагдахгүй байх юм бол өөрөө өргөдлөө өгөөд гарлаа гэхэд тэтгэмж нь арай бага, ажил олгогч нь халах юм бол, энэ чинь ямар ч шалтгаанаар халж болно шүү дээ, нөгөө хүн нь ажлаа хийхгүй байж болно, доголдол гаргасан байж болно, ёс зүйн асуудалтай байх юм бол арай урт гэхээр нэг бодлын жоохон утгагүй юм шиг болоод байгаа юм. Тэгээд МҮХАҮТ үүнийг бүр нийлүүлээд 76 хоног гэдэг хэтэрхий урт байна, ажилтан нь халсан чинь дандаа ажил олгогчийн буруу байх ёсгүй шүү дээ, аливаа зөрчлөөс үүдээд халж болно, мэргэжлийн ур чадвар нь болохгүй болоод халж болно, тэгэхээр ийм байх ёстой гэсэн саналыг МҮХАҮТ-ын “Жүр-Үр”-н захирал Мөнхзул захирал тавьсан юм. Тэгэхдээ МҮЭХ үүн дээр бүр эсрэг саналтай байгаа.

Тэгээд та бүхэн маань ойлгоорой, манай ажлын хэсэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх дэд ажлын хэсэг бол энэ олон тэс өөр саналтай талуудын саналыг нэгтгэх ийм үүрэгтэй учраас заримдаа ингээд тэс өөр саналуудыг бид аль болохоор

аль нэг талынх нь эрх ашгийг хохироохгүй авч явахыг зорьж байгаа. Тэгээд Тамир ерөнхийлөгч МҮЭХ-ны ерөнхийлөгч үүн дээр юугаа хэлчих үү? Тэгээд манай Байнгын хороо аль аль талыг нь сонсог, 8 номерын микрофон.

П.Ганзориг: 8 номер уу, нэмж тайлбарлая.

Э.Тамир: Баярлалаа. Тэгэхлээр өмнөх, жишээлбэл хууль тогтоомжийн хүрээнд хүрсэн түвшин байгаа. Яг энэ түвшнийг тодорхой түвшинд бууруулах санал манай ажил олгогчийн төлөөллийн байгууллагаас гарсан байна гэж ойлгосон. Гэтэл яг үүнтэй холбоотой, яг энэ хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дээр ажлын байрны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах зорилгоор нэг талаасаа, нөгөө талаасаа ажилгүйдлийн даатгалын сангийн алдагдлыг, тогтвортой байдлыг хангах зорилгоор оруулж ирж байсан гэж ойлгож байсан. Гэтэл одоо жишээлбэл яг энэ ажлаас чөлөөлөгдөж байгаа тэр нөхцөлийг харгалзахгүйгээр бүх нөхцөл дээр урьд нь байсан нөхцөлийг ингэж дордуулан оруулж ирж байгааг МҮЭХ эрс эсэргүүцнэ.

Тэртээ тэргүй МҮХАҮТ яг үүний үндэслэл шалтгааныг нь яг үнэндээ үндэслэлтэй гэж үзэх боломжгүй байна шүү дээ. Нэгэнтээ ажилгүйдлийн даатгалын санд ажилтан хүн, ажил олгогч аль аль нь шимтгэлээ төлчхөөд шимтгэлийнхээ дагуу авч байгаа, буцаагаад сангаас авч байгаа үйлчилгээг хязгаарлана гэж заавал ингэж оруулж ирэх тийм шалтгаан үндэслэл энэ дээр харагдахгүй байна. Тэгэхлээр магадгүй хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл дээр ажлын байрны тогтвор.../минут дуусав/

П.Ганзориг: Энхтүвшин гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 6 гишүүн дэмжиж, санал 28.6 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн орсноос 12 гишүүн дэмжиж, санал 57.1 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн нэгтгэсэн төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцэж дууслаа. Хуулийн төслийн анхны

хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганы хуралдаанд УИХ-ын гишүүн Х.Булгантуяа танилцуулна.

19.01 цаг

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх 2 асуудал байсан, 2-ланг нь хэлэлцэж дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Орой болтол хуралдаа идэвхтэй, бүрэн бүрэлдэхүүнээрээ суусан эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлье. Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд талархлаа илэрхийлье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА